

# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

... оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### **1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг иргэдийн сонгох, сонгогдох эрхийг тууштай хангаж, хууль дээдлэх, шударга ёсны дагуу зохион байгуулж явуулахад үүссэн харилцааг зохицуулахад оршино.

#### **2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж**

2.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

#### **3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."сонгогч" гэж сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэнийг;

3.1.2."сонгуулийн өдөр" гэж Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн санал авах өдрийг;

3.1.3."сонгуулийн хороод" гэж сонгуулийн тойргийн хороо, сонгуулийн тойргийн салбар хороо, сонгуулийн анхан шатны хороо болон хэсгийн хороог;

---

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.4."сонгуулийн эрх бүхий иргэн" гэж арван найман насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг;

3.1.5."арван найман насанд хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

3.1.6."хорин таван насанд хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгууль зарлах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг;

3.1.7."төрийн өмчит хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн<sup>2</sup> 13, 15 дугаар зүйлд заасан төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газрыг;

3.1.8."төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг.

#### **4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын сонгууль**

4.1.Монгол Улсын Их Хурлын сонгууль /цаашид "сонгууль" гэх/ нь Монголын ард түмэн засгийн эрх мэдлээ хэрэгжүүлэх үндсэн дээр хууль тогтоох байгууллагыг өөрсдийн шилдэг төлөөлөгчдөөр бүрдүүлэх үндсэн арга мөн бөгөөд ээлжит, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль гэсэн төрөл зүйлтэй байна.

4.2.Ээлжит сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дөрвөн жил тутам явагдаж байгаа сонгуулийг хэлнэ.

4.3.Ээлжит сонгуулийг энэ хуулийн 4.2-т заасан хугацаанд зайлшгүй хийх бөгөөд Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд сонгуулийг наашлуулах, хойшлуулахыг хориглоно.

4.4.Ээлжит бус сонгууль гэж Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/ өөрөө тарах шийдвэр гаргасан, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргасан тохиолдолд явагдах сонгуулийг хэлнэ.

4.5.Нөхөн сонгууль гэж энэ хуулийн 56.1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудлыг нөхөх зорилгоор явагдах сонгуулийг хэлнэ.

---

<sup>2</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дүгээрт нийтлэгдсэн.

4.6.Дахин сонгууль гэж Улсын Их Хурлын ээлжит, ээлжит бус сонгуулийг бүхэлд нь, эсхүл ээлжит, ээлжит бус болон нөхөн сонгуулийг тухайн нэг буюу хэд хэдэн тойрогт хүчингүй болгосны дараа шинээр улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл тухайн сонгуулийг хүчингүйд тооцсон тойрогт явагдах сонгуулийг хэлнэ.

## **5 дугаар зүйл.Сонгуулийн тогтолцооны үндэс**

5.1.Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоо нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэнэ.

5.2.Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд /цаашид “сонгуулийн эрх бүхий иргэн” гэх/ үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр нийтээрээ эрх тэгш байдлын үндсэн дээр сонгуульд оролцох эрхтэй.

5.3.Сонгууль шууд байх бөгөөд түүнд сонгогч, сонгогдогч ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, шууд сонгох ба сонгогдоно.

5.4.Сонгууль чөлөөтэй бөгөөд сонгогчоос сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, түүнчлэн саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

5.5.Сонгогч саналаа нууцаар өгөх бөгөөд хөндлөнгийн ажиглалт хяналтгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж саналаа өгөх боломжоор хангагдсан байна.

5.6.Энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан хорин таван нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхтэй.

5.7.Монгол Улсын иргэн /цаашид “иргэн” гэх/-ий сонгох, сонгогдох эрхийг хууль бусаар хязгаарлаж болохгүй.

5.8.Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон, хорих газар ял эдэлж байгаа иргэн, түүнчлэн Монгол Улсын харьяат болсон иргэн харьяат болсноос хойш 13 жилийн дотор сонгуульд оролцох эрх эдлэхгүй.

5.9."Эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр нотлогдсон" гэж Монгол Улсын Иргэний хуулийн<sup>3</sup> 18.2 дахь хэсэг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн<sup>4</sup> 141-143 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхээс иргэнийг эрх зүйн чадамжгүй гэж тооцсоныг ойлгоно.

5.10."Хорих газар ял эдэлж байгаа" гэж шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор хорих ял эдэлж байгаа иргэнийг ойлгох бөгөөд үүнд хорих ял эдлэхээс зайлсхийж яваа, хорих байгууллагаас түр чөлөөгөөр гарсан иргэнийг нэгэн адил хамааруулна.

5.11."Монгол Улсын харьяат болсон" гэж Харьяатын тухай хуулийн<sup>5</sup> 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 2 дахь заалт, 8 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын харьяат болсныг ойлгоно.

## **6 дугаар зүйл. Нэр дэвшүүлж, санал авах, санал тоолж суудал хуваарилах арга**

6.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулиар гишүүнд нэр дэвшүүлэх, сонгогчдын санал авах, саналын дүнг тооцож УИХ-ын гишүүний мандат /суудал/ хуваарилах үйл ажиллагааг олон мандаттай тойрогт хувь тэнцүүлэн сонгох аргаар зохион явуулна.

6.2.Бүсчилсэн тойрог нь нийслэлд болон хөдөөд хүн амын тооны хувьд ойролцоо буюу адил тэгш байх бөгөөд нэг сонгогч нэг тойрогт зөвхөн нэг нам, нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх адил тэгш эрхтэй оролцохоор зохион байгуулагдана.

## **7 дугаар зүйл.Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрх**

7.1.Энэ хуулийн 25.1-д заасан нам буюу намуудын сонгуулийн эвсэл /цаашид "нам, эвсэл" гэнэ/ сонгуульд оролцож намынхаа гишүүн болон намын гишүүн бус талархагч иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх эрхтэй.

7.2.Сонгогдох эрх бүхий иргэн тухайн сонгуулийн тойрогт хамрагдах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүн амын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн засаг

---

<sup>3</sup> Иргэний хууль -"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup> Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

<sup>5</sup> Харьяатын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 10-11 дугаарт нийтлэгдсэн.

захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид байнга оршин суугаа 801-ээс доошгүй сонгуулийн эрх бүхий иргэний дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.

## **8 дугаар зүйл. Сонгууль зарлах**

8.1. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн өдөр нь сонгуулийн жилийн зургадугаар сарын эхний хагасын аль нэг ням гариг байна.

8.2. Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнөх 120 хоногийн дотор, энэ хуулийн 8.1-д заасан сонгуулийн өдөр болохоос 90-ээс доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана.

8.3. Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсгийг нь хамарсан байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, дайны ба нийтийн эмх замбараагүй байдал үүссэн зэрэг онцгой нөхцөлийн улмаас Улсын Их Хурал ээлжит сонгуулийг хойшлуулсан бол уул онцгой нөхцөл арилснаас хойш 30 хоногийн дотор сонгууль товлон зарлаж, санал авах өдрийг энэ хуулийн 8.1-д заасан хугацааны дотор тогтоож, тогтоол гаргана.

## **9 дүгээр зүйл. Сонгуулийн үйл явцыг зохион байгуулж зохицуулах зарчим**

9.1. Сонгуулийн болон түүнд оролцогч төр, нам, нутгийн өөрөө удирдах болон төрийн бус аливаа байгууллага, албан тушаалтан сонгуулийн үйл явцыг зохион байгуулах, зохицуулахдаа дараахь тусгай зарчмыг гуйвалтгүй баримтална:

9.1.1. ил тод байдлыг хангах;

9.1.2. хууль дээдлэх;

9.1.3. шударга ёсыг сахих;

9.1.4. сонгогчдын эрхийг тууштай хангаж, ашиг сонирхлыг нь шүүхээр хамгаалах;

9.1.5. маргааныг шуурхай, үндэслэлтэй, шударга шийдвэрлэх;

9.1.6. сонгогчдын эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтанд хууль зүйн хариуцлага зайлшгүй хүлээлгэх;

9.1.7. сонгуулийн үйл явцад иргэний нийгмийн болон хөндлөнгийн хяналт тогтоон хэрэгжүүлэх.

9.2. Сонгууль бэлтгэн явуулах ажил ил тод байх зарчим нь энэ нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.

9.3.Төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүнчлэн аж ахуйн нэгж байгууллага нь Улсын Их Хурлын сонгуулийг бэлтгэн явуулахад энэ хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай<sup>6</sup> хууль болон холбогдох бусад хуульд заасан эрх хэмжээнийхээ дотор оролцож сонгуулийн зохих шатны хорооноос тавьсан хууль ёсны шаардлагыг хангаж тэдгээрийн ажилд туслах үүрэгтэй.

9.4.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах дүрмийн үүрэг, зорилт бүхий төрийн бус байгууллага нь сонгуулийн хороод, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад ажиглалт, хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, сонгогчдын боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд эрхээ хэрэгжүүлэхэд нь аргачлан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хууль ёсоор, шударгаар явуулахад тус дөхөм үзүүлэх эрхтэй.

## **10 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааны эдийн засгийн баталгаа**

10.1.Сонгуулийн үйл ажиллагааны дор дурдсан зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

10.1.1.сонгуулийн байгууллагын үйл ажиллагааны зардал, сонгогч, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч болон сонгуулийн ажиглагчийн үнэмлэх, түүнчлэн саналын хуудас, бие даан нэр дэвшигчийг дэмжигч сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсэг цуглуулах маягт, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн дүн, мэдээний маягт, сонгуулийн хороодын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, лац, тусгай тэмдэг тавих хэрэгсэл болон тэдгээрийг хэвлэх, үйлдвэрлэх, түгээх, хүргэх зардал;

10.1.2.саналын хайрцаг хийх, сонгуулийн хороодын ажиллах, санал авах байрыг тохижуулах зардал;

10.1.3.сонгуулийн тухай хууль тогтоомж, сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон эрх зүйн бусад акт, гарын авлага хэвлэх, хүргэх зардал;

10.1.4.сонгуулийн хороодын ажилтнуудын сонгууль зохион байгуулахтай холбогдсон сургалтын зардал;

---

<sup>6</sup> Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2007 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

10.1.5.сонгуулийн тухай хууль тогтоомжийг сурталчлах болон сонгуулийн бэлтгэл ажлын явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах арга хэмжээний зардал;

10.1.6.нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт, зарцуулалтыг хянан шалгахад гарах зардал;

10.1.7.дахин санал авах, дахин болон нөхөн сонгууль явуулах зардал;

10.1.8.онцгой нөхцөл үүссэн үед гарч болзошгүй зардал;

10.1.9.Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуулийн хороодын орон тооны бус гишүүний тухайн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшууллын зардал;

10.1.10.Сонгуулийн ерөнхий хороо болон сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан, холбоо, унаа, албан томилолтын зардал;

10.1.11.Улсын Их Хурлаас тогтоосон бусад зардал.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг Улсын Их Хурал тухай бүр тогтооно.

10.3.Сонгуулийн хороодын ажиллах, санал авах байрыг төр, орон нутгийн өмчийн болон түүний оролцоотой хуулийн этгээд үнэ хөлсгүй гаргаж өгнө.

10.4.Сонгуулийн тойргийн хорооноос бусад хороодын ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцах ба сонгуулийн тойргийн хорооны хувьд эдгээр зардлыг Засгийн газар хариуцаж улсын төсвөөс хангана.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ГАЗАР ЗҮЙ, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **11 дүгээр зүйл.Сонгуулийн газар зүй**

11.1.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг тойрогт, тойргийг хэсэгт хуваарилсныг сонгуулийн газар зүй гэнэ.

11.2.Сонгуулийн тойргийн тоо, нутаг дэвсгэр, түүний хилийн цэсийг Сонгуулийн ерөнхий хорооны өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

### **12 дугаар зүйл.Тойрог байгуулах**

12.1.Улсын Их Хурал тойргийг аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн болон Сонгуулийн ерөнхий

хорооны саналыг үндэслэн сонгуулийн өдрөөс зургаан сараас доошгүй өдрийн өмнө байгуулж, тойргийн дугаар, нутаг дэвсгэрийн цэс, төвийг тогтооно.

12.2.Улсын Их Хурал энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан тойргуудыг байгуулахдаа тэдгээрт хамрагдах хүн амын тоо адил тэнцүү байх зарчмыг баримтлан нийт хүн амыг мандатын тоонд хуваан нэг тойрогт ногдох улсын дундажийг гаргаж, хэд хэдэн аймаг, нийслэлийн дүүргийг нэгтгэн сонгуулийн нэг тойрог байхаар зохион байгуулна.

12.3.Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймгийн сум, нийслэлийн дүүргийн хороодтой түр нэгтгэн зохицуулж нэг тойрог болгоно.

12.4.Сонгуулийн ерөнхий хороо дараахь шалтгаан тохиолдвол тойргийг өөрчлөх тухай саналыг Улсын Их Хуралд оруулна:

12.4.1.засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн нутаг дэвсгэр өөрчлөгдсөн нь тойргийн зохион байгуулалтад нөлөөлөхөөр байвал;

12.4.2.тойргийн хүн амын тоо нь өмнөх сонгуулиас хойшхи хугацаанд 20-иос дээш хувиар өөрчлөгдсөн бол.

12.5.Улсын Их Хурал тойргийг өөрчлөх тухай асуудлыг энэ хуулийн 12.1-д заасан хугацаанд багтаан шийдвэрлэнэ.

### **13 дугаар зүйл.Хэсэг, түүнийг байгуулах**

13.1.Сонгогчдын санал авч тоолох зорилгоор сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хэсгийг сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, хэсгийн дугаар, нутаг дэвсгэрийн цэс, төвийг зарлана.

13.2.Нэг хэсэг нь суманд 100-1000 хүртэл, аймгийн төвд 2000-3000 хүртэл, нийслэлийн дүүрэгт 2000-4000 хүртэл сонгогчтой байж болно.

13.3.Гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэдийн саналыг авах хэсэг байгуулах журмыг Сонгуулийн ерөнхий хороо гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭН ЭРХ**

### **14 дүгээр зүйл.Сонгуулийн байгууллагын тогтолцоо, бүрэн эрхийн нийтлэг үндэслэл**

14.1.Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь Сонгуулийн ерөнхий хороо, сонгуулийн тойргийн хороо, сонгуулийн тойргийн салбар хороо, сонгуулийн анхан шатны хороо, сонгуулийн хэсгийн хорооноос бүрдэнэ.

14.2. Сонгуулийн ерөнхий хороо улсын хэмжээнд; сонгуулийн тойргийн хороо тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд; сонгуулийн тойргийн салбар хороо зохих аймаг, нийслэлийн дүүргийн хэмжээнд; сонгуулийн анхан шатны хороо зохих сум болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухайн нэгжид сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулж эрхлэн явуулна.

14.3. Сонгуулийн тойргийн болон түүний салбар хороо, анхан шатны хороо, мөн хэсгийн хороог сонгуулийн орон нутгийн байгууллага гэх бөгөөд тэдгээр нь энэ хуульд заасан журмаар хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

14.4. Сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд зөвхөн шүхс үгчээс бусад төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийг томилон ажиллуулна.

14.5. Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч сонгуулийн хороодын бүрэлдэхүүнд байж болохгүй.

14.6. Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн Улсын Их Хурлаас баталсан Сонгуулийн хорооны гишүүний ёс зүйн дүрмийг баримтлан ажиллана.

14.7. Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмаар ажиллах ба дээд шатны хорооны хууль ёсны шийдвэрийг доод шатны нь хороо заавал биелүүлэх бөгөөд доод шатны хорооны хууль бус шийдвэрийг дээд шатны нь хороо хүчингүй болгох эрхтэй.

14.8. Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн аль нэгэн нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар ухуулга хийх, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд, түүнчлэн санал хураах, тоолох ажилд санаатайгаар саад хийх, бусдыг төлөөлж санал өгөх, саналын хайрцгийн лац, битүүмжлэлийг гэмтээх, гарын үсэг хуурамчаар үйлдэх, саналын хуудас солих, саналын хүчингүй хуудсаар санал авах зэрэг аливаа үйлдлийг зохион байгуулах, өөгшүүлэх, хууль бус бусад хэлбэрээр дэмжихийг хориглоно.

14.9. Сонгуулийн хороодоос сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгахад төрийн албан хаагч, сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч хөндлөнгөөс оролцох, саад учруулахыг хориглоно.

14.10. Сонгууль зохион байгуулж явуулах хугацаанд сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд дээд шатны сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажилд шилжүүлэх, захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

14.11. Энэ хуулийн 14.8-д заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах

бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

14.12.Энэ хуулийн 14.8-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай<sup>7</sup>, Прокурорын байгууллагын тухай<sup>8</sup>, Шүүхийн тухай<sup>9</sup> хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

### **15 дугаар зүйл. Сонгуулийн ерөнхий хороо, түүний бүрэн эрх**

15.1. Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төв байгууллага мөн.

15.2. Сонгуулийн ерөнхий хорооны эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.

### **16 дугаар зүйл. Сонгуулийн тойргийн хороо, түүний бүрэн эрх**

16.1. Сонгуулийн тойргийн хороог /цаашид “тойргийн хороо” гэх/ Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн өдрөөс 80-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 9 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, улсын хэмжээнд нийтлэн мэдээлнэ.

16.2. Тойргийн хороо тойргийнхоо хэмжээнд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.2.1. сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөх, сонгуулийн үйл явцыг зохион байгуулах бүхий л арга хэмжээг авах;

16.2.2. сонгуулийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

16.2.3. харьяалах аймаг, нийслэлийн дүүрэг дэх тойргийн салбар хороо /цаашид “салбар хороо” гэх/-г зохион байгуулалт, арга зүйн талаар нэгтгэн удирдах;

16.2.4. сонгууль бэлтгэн явуулах асуудлаар тухайн тойргийн нутаг дэвсгэрт байгаа төрийн зохих шатны байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

16.2.5. Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах салбар хороонд зохих журмын дагуу хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

16.2.6. нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох;

---

<sup>7</sup> Цагдаагийн байгууллагын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1993 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Прокурорын байгууллагын тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup> Шүүхийн тухай хууль - “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 29 дугаарт нийтлэгдсэн.

16.2.7.сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар харьяалах салбар хороо, түүнчлэн тухайн тойргийн нутаг дэвсгэрийн зохих шатны төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдагчдын мэдээллийг сонсож, шаардлагатай арга хэмжээ авах;

16.2.8.харьяалах салбар хорооны шийдвэрийн талаархи өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

16.2.9.санал хураасан дүнгийн тухай харьяалах салбар хорооны шийдвэрийг үндэслэн тухайн тойргийн хэмжээнд сонгуулийн дүнг нэгтгэн мандат хуваарилж, Сонгуулийн ерөнхий хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

16.2.10.дахин санал авах, дахин болон нөхөн сонгууль явуулах ажлыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах;

16.2.11.сонгууль бэлтгэн явуулахтай холбогдуулан дээд шатны сонгуулийн хорооноос өгсөн үүргийг биелүүлэх;

16.2.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

## **17 дугаар зүйл.Салбар хороо, түүний бүрэн эрх**

17.1.Тойргийн хорооны харьяанд тухайн тойрогт хамрагдаж байгаа аймаг бүрт, түүнчлэн нийслэлийн нэгэн тойрогт хамрагдаж дүүрэг тус бүрт тойргийн салбар хороо байна.

17.2,Салбар хороог тойргийн хороо сонгуулийн өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, тойргийн хэмжээнд нийтлэн мэдээлнэ.

17.3.Салбар хороо нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ хуулийн 16.2.1, 16.2.2, 16.2.5, 16.2.11-д заасан бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.3.1.харьяалах сонгуулийн анхан шатны болон хэсгийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

17.3.2.тойргийн хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, харьяалах сонгуулийн анхан шатны болон хэсгийн хороонд зохих журмын дагуу хуваарилах, зарцуулалтад хяналт тавих;

17.3.3.сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар харьяалах сонгуулийн анхан шатны болон хэсгийн хороо, түүнчлэн тухайн нутаг дэвсгэрийн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдагчдын мэдээллийг сонсож, шаардлагатай бол зохих арга хэмжээ авах;

17.3.4.харьяалах сонгуулийн анхан шатны хорооны шийдвэрийн талаархи өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

17.3.5.санал хураасан дүнгийн тухай харьяалах сонгуулийн анхан шатны хорооны шийдвэрийг үндэслэн тухайн аймаг, дүүргийн хэмжээгээр сонгуулийн дүнг нэгтгэж, тойргийн хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

17.3.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

### **18 дугаар зүйл.Сонгуулийн анхан шатны хороо, түүний бүрэн эрх**

18.1.Тухайн аймаг, нийслэлийн дүүрэг дундын тойргийн хорооны нутаг дэвсгэрт хамаарах бух сум, дуурэгт сонгуулийн анхан шатны хороог зохих салбар хороо сонгуулийн өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тухайн аймаг, нийслэлийн дүүргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

18.2.Сонгуулийн анхан шатны хороо нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ хуулийн 16.2.1, 16.2.2, 16.2.5, 16.2.11-д заасан бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.2.1.харьяалах хэсгийн хороодын үйл ажиллагааг нэгтгэн удирдах;

18.2.3.сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар харьяалах хэсгийн хороо, түүнчлэн тухайн нутаг дэвсгэрийн төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдагчдын мэдээллийг сонсож, шаардлагатай бол зохих арга хэмжээ авах;

18.2.4.харьяалах хэсгийн хорооны шийдвэрийн талаархи өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

18.2.5.санал хураасан дүнгийн тухай харьяалах хэсгийн хорооны шийдвэрийг үндэслэн тухайн сум, дуургийн хэмжээгээр сонгуулийн дүнг нэгтгэж, салбар хороонд хүргэх, олон нийтэд мэдээлэх;

18.2.6.хуульд заасан бусад бүрэн эрх.

### **19 дүгээр зүйл.Хэсгийн хороо, түүний бүрэн эрх**

19.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, түүний хүн амын тархалт, төвлөрөл, сонгогчдын тоо сонгуулийн анхан шатны хорооны саналыг харгалзан тойргийн хорооны баталсан бүдүүвч /схем/-ийн дагуу сонгуулийн хэсгийн хороог салбар хороод сонгуулийн өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих сум, дүүрэг, баг, хорооны хэмжээнд нийтэд мэдээлнэ.

19.2.Хэсгийн хорооны бүрэлдэхүүний тоог сонгогчдын тоо, ажлын хэмжээг харгалзан дор дурдсанаар тогтооно:

19.2.1.тухайн хэсэгт 1000 хүртэл сонгогчтой бол 7;

19.2.2.тухайн хэсэгт 1001-3000 хүртэл сонгогчтой бол 9, эсхүл 11;

19.2.3. тухайн хэсэгт 3000-ээс дээш сонгогчтой бол 11, эсхүл 13.

19.3. Хэсгийн хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

19.3.1. хэсгийн хорооны хаяг, ажиллах цагийн хуваарь, санал авах өдөр, цагийг сонгогчдод мэдээлэх;

19.3.2. сонгогчийн үнэмлэх олгох;

19.3.3. сонгогчийг шилжүүлэх, шилжиж ирсэн сонгогчийг бүртгэх;

19.3.4. сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хэмжээнд үнэн зөв нэгтгэж, сонгогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, оршин суугаа газрын хаяг зэргийг тулган шалгах;

19.3.5. санал авах байр, саналын үндсэн болон зөөврийн хайрцаг зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэж, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах;

19.3.6. санал хураалтын дүнг нэгтгэн гаргаж, сонгуулийн анхан шатны хороонд нэн даруй хүргэх;

19.3.7. сонгууль бэлтгэн явуулах болон санал хураах, санал тоолохтой холбогдсон асуудлаар гарсан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ дотор шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад уламжлах;

19.3.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

## **20 дугаар зүйл. Сонгуулийн хороодын ажлын зохион байгуулалт**

20.1. Сонгуулийн хороод эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

20.2. Тухайн хорооны хуралдааныг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол хүчинтэйд тооцно.

20.3. Энэ хуулийн 20.1-д заасан тогтоолд тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

20.4. Сонгуулийн хороод хуралдаанаараа дэгээ тогтоон батлах бөгөөд түүнд үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, гишүүдийн ажил үүргийн хуваарь, ажиллах зарчим, журмыг тусгасан байна.

20.5. Сонгуулийн хороодын хуралдааныг нээлттэй явуулж, шийдвэрийг ил тод мэдээлнэ.

20.6. Сонгуулийн хороодын хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу заавал хөтлөх бөгөөд түүнийг тухайн хорооны нэг гишүүнд хариуцуулна.

20.7.Сонгуулийн баримт бичиг бүртгэлтэй байх бөгөөд түүнд хамаарах баримт бичиг, түүнийг бүртгэх журмыг Сонгуулийн ерөнхий хороо тогтооно.

20.8.Сонгуулийн хорооны дарга дотоод ажлын асуудлаар захирамж гаргана.

20.9.Сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг үндсэн ажлаас нь түр чөлөөлөн ажиллуулна.

20.10.Хуульд өөрөөр заагаагүй бол доод шатны сонгуулийн хорооны шийдвэрийн талаар дээд шатны нь хороонд гомдол гаргаж болох бөгөөд зохих шатны хороо гомдлыг хүлээж авснаас хойш ажлын гурван өдрийн дотор хянан шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр хариу мэдэгдэнэ.

20.11.Сонгуулийн хороод сонгууль бэлтгэн явуулахтай холбогдсон асуудлаар сонгуулийн тухай хууль тогтоомжоор үүрэг хүлээсэн аливаа байгууллага, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавих эрхтэй бөгөөд түүнийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан уул шаардлагыг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.

20.12.Сонгуулийн хороодоос бүрэн эрхийнхээ дотор гаргасан шийдвэрийг сонгуулийн тухай хууль тогтоомжид заасны дагуу үүрэг хүлээсэн тухайн нутаг дэвсгэрийн бүх байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

20.13.Сонгуулийн хороод сонгуулийн баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу цэгцэлж, харьяалагдах дээд шатныхаа хороонд албан ёсоор хүлээлгэн өгнө.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ, СОНГОГЧИЙН ҮНЭМЛЭХ**

### **21 дүгээр зүйл. Сонгогчдын нэрийн жагсаалт**

21.1.Сонгогчдын нэрийн жагсаалт бол Монгол Улсын иргэний бүртгэлийн салшгүй хэсэг бөгөөд иргэд нийтээрээ сонгох, сонгогдох эрхээ хангах хууль зүйн зайлшгүй нэг үндэс мөн.

21.2.Сонгогч нь өөрийн оршин суугаа нутаг дэвсгэрийн сонгуулийн зөвхөн нэг хэсэгт нэг нэрийн жагсаалтад бүртгүүлэн сонгогчийн үнэмлэх авах, хэрэв сонгуулийн хугацаанд түр болон бүрмөсөн шилжвэл уул жагсаалтаас хасуулж, очсон газрынхаа сонгуулийн хэсэгт бүртгүүлэх эрх, үүрэгтэй.

21.3.Өөрийн Тамгын газар ба улсын бүртгэлийн албыг татан оролцуулж тус тусын нутаг дэвсгэрийн хэмжээнд сонгогчдын нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд үнэн зөв, давхардал, хийдэлгүй бүрэн гаргаж сонгуулийн хороодод хүргүүлэх нь тухайн баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын албан тушаалтны үүрэг, хариуцлага мөн.

21.4.Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, магадлан хянах техник ажиллагааг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн алба, ажилтан эрхлэн гүйцэтгэнэ.

21.5.Улсын бүртгэлийн албаны ажилтан нэрийн жагсаалтыг дараахь журмыг баримтлан үйлдэх үүрэгтэй:

21.5.1.сум, дүүргийн улсын бүртгэл хариуцсан ажилтан Сонгуулийн ерөнхий хорооны баталсан маягтын дагуу баг, хорооны хүн амын хаягийн бүртгэл, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулийн жилийн гуравдугаар сарын нэгний дотор гаргаж аймаг, дүүргийн /нийслэлийн/ улсын бүртгэлийн албанд хүргүүлэх;

21.5.2.аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын бүртгэлийн алба нь өөрт ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг зохих хууль, заавар, маягтын дагуу хянан үзэж аймаг, нийслэлийн хэмжээгээр нэгтгэн 2 хувь үйлдэж сонгуулийн өдрөөс гурван сарын өмнө Улсын бүртгэлийн ерөнхий газар уламжилан Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх;

21.5.3.Улсын бүртгэлийн ерөнхий газар хүн амын нэгдсэн бүртгэлийн үндсэн дээр аймаг, нийслэлийн албадаас ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг 20 хоногийн дотор хүн амын бүртгэлтэй тулган шалгаж, үнэн зөвийг тодорхойлон Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлэх.

21.6.Сонгуулийн ерөнхий хороо нь сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрээр гаргасан сонгогчдын нэрийн жагсаалтыг вэб хуудаст байрлуулж, уг жагсаалтыг сонгуулийн өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө салбар хороогоор дамжуулан хэсгийн хороонд хүргүүлнэ.

21.7.Хэсгийн хороо энэ хуулийн 21.6-д заасны дагуу ирүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж, сонгуулийн өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө нэгтгэн 2 хувь үйлдэж, хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэгтэйгээр сонгуулийн өдрөөс 15-аас доошгүй хоногийн өмнө хэсгийнхээ санал авах байранд ил тавьж сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.

21.8.Энэ хуулийн 21.6-д заасан вэб хуудаст байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай нам, эвсэл, нэр дэвшигч, түүнчлэн сонгогч танилцах боломжтой байвал зохино.

## **22 дугаар зүйл.Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, түүний үр дагавар**

22.1.Сонгогчдын нэрсийн жагсаалт нь үндсэн ба зөөврийн битүүмжилсэн хайрцагаар санал хураах гэсэн хоёр янз байх бөгөөд эдгээрийг ээлжит сонгууль бүрээр шинэчлэн гаргана.

22.2.Сонгуулийн хороод нь тойрог, хэсгийн сонгогчдын тоог Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу зөвхөн сонгуулийн хэсгийн хороонд байгаа нийтэд танилцуулсан сонгогчдын нэрийн жагсаалтыг баримтлан гаргана.

22.3. Сонгогчдын нэрийн жагсаалтад түүнийг үйлдэх үед тухайн хэсэгт байнга буюу түр оршин суугаа бүх сонгогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, оршин суугаа газрын хаяг, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаарыг бүртгэх бөгөөд сонгогчийн нэрийг оршин суугаа газрын байршлаар нь өөрийн нэрийн цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ.

22.4. Эмнэлэг, амралт, сувиллын газар, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цэргийн анги салбарын захиргаа нь сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд шаардагдах мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

22.5. Сонгогч сонгуулийн хэсэг дэх сонгогчдын нэрийн жагсаалттай биечлэн танилцаад хэрэв бүртгээгүй буюу буруу бүртгэсэн байвал хэсгийн хороонд бүртгүүлэх, зөвтгөх хүсэлт гаргах бөгөөд уг хүсэлтийг хүлээн авахгүй бол дараахь журмаар гомдлоо гаргаж шийдвэрлүүлнэ:

22.5.1. гомдлыг хэсгийн хороогоор дамжуулж гаргах;

22.5.2. хэсгийн хороо гомдлыг гурван өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд хэрэв сонгуулийн өдөр болон уул өдөр хүртэлх гурван өдрийн хугацаанд гомдлыг хүлээн авсан бол нэн даруй хянан үзэж шийдвэрлэн хариу мэдэгдэх;

22.5.3. хэсгийн хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл сонгогч сонгуулийн анхан шатны хороонд, түүний шийдвэрийг эс зөвшөөрвөл захиргааны хэргийн шүүхэд тус тус гомдол гаргах.

22.6. Аливаа байгууллага, албан тушаалтан сонгогчдын нэрийн жагсаалтыг Сонгуулийн ерөнхий хорооны зөвшөөрөлгүйгээр хувилж олшруулах, тараахыг хориглоно.

### **23 дугаар зүйл. Сонгогч шилжих хөдөлгөөнийг бүртгэх**

23.1. Хэсгийн хороо энэ хуулийн 21.7-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг нийтэд зарласнаас хойш саналын хуудас хүлээн авах хүртэлх хугацаанд сонгогч албан томилолтоор буюу өвчний учир зэрэг хувийн хэргээр өөр хэсэг буюу тойрогт байнга болон түр хугацаагаар шилжвэл энэ тухайгаа бичгээр хэсгийн хороонд мэдүүлэн шилжүүлэг хийлгэж, сонгогчдын нэрийн жагсаалтаас хасуулна.

23.2. Энэ хуулийн 23.1-д заасны дагуу шилжсэн сонгогч нь шилжүүлэг хийсэн тэмдэглэл бүхий сонгогчийн үнэмлэх, иргэний үнэмлэхээ хянуулж, очсон газрынхаа хаягаар сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгүүлнэ.

23.3. Хэсгийн хороо энэ хуулийн 23.1-д заасан журмын дагуу шилжин ирсэн сонгогчийг сонгогчдын нэрсийн нэмэлт жагсаалтад бүртгэнэ.

23.4. Хэсгийн хороо нь саналын хуудас хүлээн авснаас хойш шилжүүлэг хийхийг хориглоно.

23.5.Энэ хуулийн 23.3, 23.4-т заасныг зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

#### **24 дүгээр зүйл. Сонгогчийн үнэмлэх, түүнийг олгох**

24.1. Сонгогчийн үнэмлэх нь таних нууц тэмдэг /бар код/-тэй байх бөгөөд сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгуулийн хэсэгт санал өгөх эрхийн үндсэн баримт бичиг мөн.

24.2. Сонгогчийн үнэмлэхэд сонгогчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, нас, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг бичнэ.

24.3. Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчид сонгогчийн үнэмлэх бичиж, хэсгийн хорооны гишүүнээр хүргүүлнэ.

24.4. Сонгогчийн үнэмлэх тараасан хэсгийн хорооны гишүүний нэрийг сонгогчдын нэрийн жагсаалт дахь сонгогчийн нэрийн ард, үнэмлэх хүлээн авсан хүний гарын үсгийг үнэмлэх тараасан хүснэгтэд тус тус зуруулна.

24.5. Энэ хуулийн 24.1-д заасныг зөрчиж нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогчид сонгогчийн үнэмлэх олгосон этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

### **ТАВДУГААР БҮЛЭГ НАМ, ЭВСЭЛ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ**

#### **25 дугаар зүйл. Нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлэх**

25.1. Сонгууль зарлахаас өмнө улсын бүртгэлд бүртгүүлсэн нам нь сонгуульд Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлж оролцох эрхтэй.

25.2. Хоёр буюу хэд хэдэн нам сонгуульд нэгэн эвсэл болон оролцож болох ба энэ тохиолдолд энэ хуулийн 25.1 дэх хэсгийн заалт эвсэлд нэгдэн орж байгаа нам тус бүрт адил хамаарна.

25.3. Нам, эвсэл сонгуульд оролцох хүсэлтээ сонгуулийн өдрөөс 75-аас доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд бичгээр илэрхийлж, албан ёсоор бүртгүүлнэ.

25.4. Нам, эвсэл сонгуульд оролцох хүсэлтдээ дараахь баримт бичгийг хавсарган Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ:

25.4.1.сонгуульд нам дангаараа, эсхүл эвсэл байгуулж оролцох тухай шийдвэр;

25.4.2.намын буюу эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудын улсын бүртгэлд бүртгүүлсэн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

25.4.3.нам, эвслийн сонгуулийн батлагдсан мөрийн хөтөлбөр;

25.4.4.өмнөх сонгуулиас хойшхи хугацаанд тухайн намд буюу эвсэлд нэгдэн орсон намуудад иргэд, хуулийн этгээдээс өгсөн хандивын аудитын байгууллагаар хянуулж баталгаажуулсан тайлан;

25.4.5.нам, эвслийн сонгууль эрхлэх төв байгууллагын нэр, бүрэлдэхүүн, хаяг, утасны дугаар.

25.5.Эвсэлд нэгдсэн намуудын төлөөлөх байгууллага нь энэ хуулийн 25.4-т зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлж Сонгуулийн ерөнхий хороонд өгнө:

25.5.1.эвслийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

25.5.2.эвсэлд нэгдэн орсон нам тус бүрийн удирдах дээд байгууллагын энэ хуулийн 26.1-д заасан хуралдааны тэмдэглэл, шийдвэр.

## **26 дугаар зүйл.Намууд сонгуулийн эвсэл байгуулах, эвслийн гэрээ**

26.1.Энэ хуулийн 25.1-д зааснаар улсын бүртгэлд бүртгүүлсэн намууд Улсын Их Хурлын тухайн ээлжит сонгуульд эвсэл байгуулж оролцох бол түүнд нэгдэн орох нам тус бүр өөрийн Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдааныг хийж, дараахь асуудлыг шийдвэрлэнэ:

26.1.1.эвслийн нэр, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцэн батлах;

26.1.2.эвсэлд нэгдэн орох нам тус бүрт ногдох мандатын тоог тогтоох;

26.1.3.нам тус бүр өөрт ногдсон мандатад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;

26.1.4.цаашид сонгуультай холбогдсон асуудлаар эвсэлд тухайн намыг төлөөлөн шийдвэр гаргах эрхтэйгээр оролцох төлөөлөгчид /цаашид "төлөөлөх байгууллага" гэх/-ийг томилох;

26.1.5.эвслийн гэрээг хэлэлцэж, дэмжих эсэхээ илэрхийлэх.

26.2.Энэ хуулийн 26.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 26.1.3-т заасан асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.

26.3.Эвсэлд нэгдэн орох намууд тус бүртээ энэ хуулийн 26.1-д заасан асуудал тус бүрийг шийдвэрлэж, эвслийн гэрээ байгуулж, түүнд намуудын дарга

нар гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан бол эвслийг албан ёсоор байгуулагдсанд тооцно.

26.4.Эвсэл албан ёсны нэртэй байх бөгөөд түүнийг хувь хүн, улс, үндэстэн, овгийн нэрээр болон урьд нь өөр намуудын эвслийн хэрэглэсэн нэрээр нэрлэхийг тус тус хориглох ба нэгэнт зарлагдсан эвслийн нэрийг сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөрчлөхийг хориглоно.

26.5.Энэ хуулийн 26.1, 26.3-т заасны дагуу нэгэнт байгуулагдсан эвсэлд сонгуулийн явцад болон шинээр сонгогдсон Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд өөр нам нэгдэж орохыг хориглоно.

26.6.Эвслийн төлөөлөх байгууллага нь эвсэлд нэгдэн орсон нам бүрээс энэ хуулийн 26.1.4-т заасны дагуу томилогдсон төлөөлөгчдөөс бүрдэх бөгөөд эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, гэрээнд өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд зэрэг улс төрийн албан тушаалд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг татан гаргах, түүний оронд өөр хүний нэр дэвшүүлэх, нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, эвслийн гэрээг цуцлах зэргээр сонгууль болон эвсэлтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх боловч энэ хуулийн 26.1.2-т заасны дагуу намуудад ногдсон мандатын тоог өөрчлөх эрхгүй.

26.7.Эвслийн гэрээнд талуудын нийтлэг болон харилцан хүлээх эрх, үүрэг, эвслийн нэр, эвслийг төлөөлөх байгууллага, түүний удирдах бүрэлдэхүүнд орсон иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүнийг төлөөлөх албан тушаалтны овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр болон харилцан тохиролцсон хуульд харшлахгүй бусад асуудлыг тусгах бөгөөд уул гэрээ нь тухайн сонгууль, түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

26.8.Эвсэлд нэгдэн орсон намууд нь Улсын Их Хурлын ээлжит болон түүний бүрэн эрхийн хугацаан дахь нөхөн сонгууль, түүнчлэн шинээр сонгогдсон Улсын Их Хуралд нэгэн этгээд болж оролцоно.

26.9.Эвслийн аль нэг нам дангаараа /эвслээс гадуур/ нэр дэвшүүлэх, сонгуулийн зардлын данс нээлгэх, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан сонгуульд орохыг хориглох бөгөөд хэрэв аль нэг нам нь ийм шийдвэр гаргасан бол эвслийг тарсан гэж үзнэ.

26.10.Эвсэлд нэгдэн орсон нам хэдийд ч эвслээс гарах эрхтэй бөгөөд түүний энэ хуулийн 26.1-д заасан байгууллага нь мөн хуулийн 26.6-д заасан төлөөлөх байгууллагад энэ тухай албан ёсоор мэдэгдсэнээр тухайн намыг эвслээс гарсанд тооцох бөгөөд энэ тохиолдолд эвслийг бүхэлд нь тарсан гэж үзнэ.

26.11.Энэ хуулийн 26.1.4-т заасан төлөөлөх байгууллага эвслийн гэрээг хэдийд ч цуцалж болно.

26.12.Анхнаасаа эвсэлд нэгдээгүй намууд, түүнчлэн энэ хуулийн 26.9-26.11-д заасны дагуу эвсэл нэгэнт тарсан бол Улсын Их Хурлын тухайн сонгуулийн явцад болон түүний үр дүнд байгуулагдсан Улсын Их Хуралд эвслийн Засгийн газар байгуулахаас бусад тохиолдолд дахин нэгдэж эвсэл байгуулах, мөн нэгдсэн нэг бүлэг болон зохион байгуулагдахыг хориглох бөгөөд энэ заалт нь эвслээс гарсан нам 8-аас дээш суудалтай бол дангаараа бүлэг байгуулахад хамаарахгүй.

## **27 дугаар зүйл. Сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх**

27.1. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу сонгуульд оролцохоо илэрхийлсэн нам, эвслийг бүртгэхдээ тэдгээрийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэхийг нягтлан шалгана.

27.2. Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 25.4, 25.5-д заасан баримт бичгийг үндэслэн тэдгээрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдөрт багтаан сонгуульд оролцох нам, эвслийг бүртгэх эсэх тухай шийдвэр гаргана.

27.3. Дараахь тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзана:

27.3.1. нам буюу эвсэлд нэгдэн орсон намуудын аль нэг нь энэ хуулийн 25.1-д заасан шаардлага хангаагүй бол;

27.3.2. энэ хуулийн 25.4, 25.5-д заасан баримт бичиг дутуу, агуулгын зөрчилтэй, эсхүл хуурамч бол;

27.3.3. энэ хуулийн 25.4, 25.5-д заасан аль нэгэн баримт бичгийг мөн хуулийн 25.3-т заасан хугацаа дууссанаас хойш ирүүлсэн бол;

27.3.4. эвсэл байгуулах тухай шийдвэр гаргахдаа энэ хуулийн 26.1-26.4-т заасан журам, шаардлагыг зөрчсөн бол;

27.3.5. эвсэлд нэгдэн орсон аль нэг нам нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлсэн бол;

27.3.6. өмнөх ээлжит болон нөхөн сонгуулийн явцад сонгуулийн хууль зөрчсөн тухай маргаанд хариуцагчаар татагдан шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа, түүнчлэн өмнөх сонгуулийн зардлын тайланг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол.

27.4. Сонгуулийн ерөнхий хороо нам, эвслийг бүртгэсэн тухай шийдвэр гаргасан бол батламж олгоно.

27.5. Нам, эвслийг бүртгэхээс татгалзсан тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргаж болно.

27.6.Энэ хуулийн 27.4-т заасны дагуу эвсэл сонгуульд оролцохоор бүртгүүлснээс хойш түүнд аль нэг нам, эвсэл нэгдэн орохыг хориглоно.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, НЭР ДЭВШИГЧИЙГ БҮРТГЭХ**

### **28 дугаар зүйл.Нэр дэвшүүлэх нийтлэг журам**

28.1.Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг сонгууль зарласнаас хойш 10 хоногийн дараа эхлүүлж, 15 хоногийн хугацаанд дуусгана.

28.2.Энэ хуулийн 32 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчээр бүртгүүлж, үнэмлэх авсан иргэнийг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигч /цаашид "нэр дэвшигч" гэх/ гэж үзнэ.

28.3.Нэр дэвшигч нь нэгээс илүү тойрогт нэр дэвшиж болохгүй,

28.4.Нэг намын гишүүнийг нөгөө намаас, эвслийн тухайд түүнд нэгдэн орсон намуудынхаас өөр намын гишүүнийг нэр дэвшүүлэхгүй.

28.5.Нам, эвсэл аливаа нэг намын гишүүн бус иргэнийг түүний бичгээр гаргасан зөвшөөрлийн үндсэн дээр нэрийг нь дэвшүүлж болно.

### **29 дүгээр зүйл.Нэр дэвшигчид тавих үндсэн болон тусгай шаардлага**

29.1.Нэр дэвшигчид Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар дараахь үндсэн шаардлага тавина:

29.1.1.Монгол Улсын иргэн байх;

29.1.2.сонгууль зарласан өдөр 25 насанд хүрсэн байх;

29.1.3.сонгуулийн эрх бүхий буюу эрх зүйн бүрэн чадамжтай байх.

29.2.Улсын Их Хурлын гишүүний хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэх эрхэм нэр хүнд бүхий өндөр хариуцлагатай уялдан хууль зүйн дараахь тусгай шаардлагыг нэр дэвшигчид тавина:

29.2.1.ялгүй буюу ял эдлэхээс чөлөөлөгдсөн (хугацаа дууссан, өршөөгдсөн, уучлагдсан) боловч Эрүүгийн хуулийн 78 дугаар зүйлд зааснаар ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дууссан;

29.2.2.нэр дэвших үед гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр татагдаагүй, эсхүл татагдсан боловч өршөөлөөр хэрэгсэхгүй болгогдсон байх;

29.2.3.захиргааны ноцтой зөрчил гаргаж захиргааны журмаар баривчлагдсан, эсхүл давтан буюу удаа дараагийн үйлдэлд торгууль хүлээсэн боловч хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан байх;

29.2.4.банк, бусад хуулийн этгээд, иргэдэд шүүхээр нэхэмжлэгдсэн их хэмжээний зээлийн өргүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өр болон хугацаа хэтэрсэн албан татварын өр төлбөргүй байх;

29.2.5.гадаадад байнга оршин суугаа бөгөөд хөрөнгө орлого нь гадаадад бүртгэлтэй иргэн биш байх;

29.2.6.цэргийн жинхэнэ хугацаат алба хаах насны иргэн Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн<sup>7</sup> дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлсэн байх;

29.3.Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө 25 нас хүрсэн иргэнд энэ хуулийн 29.2.6 дахь заалт хамаарахгүй.

29.4.Төрийн жинхэнэ албан хаагч Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших болсон бол энэ хуулийн 32.2-т заасан баримт бичгийг холбогдох сонгуулийн хороонд хүргүүлэхээс өмнө Төрийн албаны тухай хуульд<sup>8</sup> заасны дагуу уг албанаас чөлөөлөгдсөн байна.

29.5.Энэ хуулийн 29.4-т зааснаар чөлөөлөгдсөн иргэн сонгууль дууссанаас хойш 2 жилийн дотор төрийн жинхэнэ алба хаших эрх эдлэхгүй.

### **30 дугаар зүйл. Нам, эвслээс нэр дэвшүүлэх**

30.1.Нам, эвсэл нь тойрогт ногдох мандатын тооноос илүүгүй хүнийг дор дурдсан журмаар нэр дэвшүүлнэ:

30.1.1.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан үндсэн ба тусгай шаардлагыг хангасан намын гишүүн ба гишүүн бус хүнийг намын дүрмийг баримтлан анхан шатны намын байгууллагаас эхлэн нэр дэвших, шилж сонгогдох адил тэгш боломж олгох үндсэн дээр шалгаруулах;

---

<sup>7</sup> Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup> Төрийн албаны тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

30.1.2.энэ хуулийн 30.1.1-д заасны дагуу нэр дэвшүүлэхдээ улс төрийн хуйвалдаан зохион байгуулах, эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, хууран мэхлэх үйл ажиллагаа явуулахыг хориглох;

30.1.3.намаас нэр дэвшүүлэх асуудлыг Улс төрийн намын тухай хуулийн<sup>9</sup> 13.7-д заасны дагуу тухайн намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын хуралдаанаар хэлэлцэж, нууцаар санал хурааж, ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх;

30.1.4.хэдэн тойрогт хэдэн хүн, хэн хэнийг нэр дэвшүүлэхийг шийдвэрлэхдээ тойрог тус бүрт өрсөлдүүлэн шалгаруулах ба хэрэв өрсөлдүүлэх хүн байхгүй бол тухайн хүний нэрийг шууд дэвшүүлэх;

30.1.5.тойрогт ногдсон мандатын тоогоор нэр дэвшүүлэхдээ олонхийн санал авсан хүний нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар тоогоор дугаарлан жагсааж бичих;

30.1.6.нам нэр дэвшүүлэхдээ тухайн хун Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвартай эсэх, эх орон, ард түмнийхээ тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэлтэй эсэх, шударга ёс, хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадвартай эсэхийг харгалзан үзэх;

30.1.7.намаас нэр дэвшүүлэх асуудлыг шийдвэрлэсэн хуралдааны шийдвэрт намын Их Хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага, гишүүдийн тоо, хуралдаанд оролцсон гишүүдийн ирц, нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтыг тойрог тус бүрээр, санал авсан хувь, нэр дэвшүүлсэн хүн энэ хуульд заасан болзол, шаардлагыг хангасан талаар тусгах.

30.2.Эвслээс нэр дэвшүүлэхэд энэ хуулийн 26.1.2, 26.1.3, 26.2-т заасан журмыг баримтална.

30.3.Нам, эвсэл нэр дэвшүүлэх талаар энэ хуулийн заалтад нийцүүлэн өөрсдийн дотоодод мөрдөх аргачилсан журмыг тогтоон мөрдөж болно.

### **31 дүгээр зүйл. Бие даан нэр дэвшүүлэх**

31.1.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 7.2-т заасан тооны дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэний гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтын дагуу зуруулж, тойргийн хороонд 7хоногийн дотор ирүүлнэ.

31.2.Бие даан нэрээ дэвшүүлэгч нь энэ хуулийн 31.1-д заасан дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэний дэмжлэгийг авахдаа тухайн тойрогт хамрагдах

---

<sup>9</sup>Улс төрийн намын тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2005 оны дугаарт нийтлэгдсэн.

аймаг, нийслэлийн дүүрэг бүрийн хүн амын /иргэдийн/ төлөөллийг оролцуулсан байна.

31.3.Энэ хуулийн 31.1-д заасан бие даан нэрээ дэвшүүлэгчийг дэмжиж, гарын үсэг зурсан сонгуулийн эрх бүхий иргэн нь тухайн тойрогт хамрагдах аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын бүртгэлд бүртгэгдсэн, тухайн аймаг, нийслэлийн дүүрэгт байнга оршин суугч сонгуулийн эрх бүхий иргэн байна.

31.4.Энэ хуулийн 31.1-д заасан маягтад дэмжигч сонгуулийн эрх бүхий иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, оршин суугаа газрын хаягийг гаргацтай, тодорхой бичсэн байх бөгөөд уг мэдээллийг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

## **32 дугаар зүйл.Нэр дэвшигчийг бүртгэх**

32.1.Нэр дэвшигчийг тойргийн хороо бүртгэнэ.

32.2.Нэр дэвшүүлсэн нам, эвсэл нь энэ хуулийн 28.1-д заасан нэр дэвшүүлэх ажиллагаа дууссан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан дараахь баримт бичгийг тойргийн хороонд ирүүлнэ:

32.2.1.нэр дэвшүүлсэн тухай шийдвэр, тэмдэглэл;

32.2.2.нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт, хүн бүрийн бичгээр өгсөн зөвшөөрөл;

32.2.3.нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын мэдүүлэг;

32.2.4.энэ хуулийн 29.4.2-т заасан өр төлбөргүй болох тухай нэр дэвшигчийн мэдүүлэг, эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

32.2.5.ялгүйг нотолсон цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

32.2.6.төрийн жинхэнэ албан хаагчийг нэр дэвшүүлсэн бол түүний тухайд ажлаас чөлөөлөгдсөн тухай шийдвэр;

32.2.7.Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан загварын дагуу үйлдсэн нэр дэвшигчийн намтар.

32.3.Бие даан нэр дэвшигч нь энэ хуулийн 28.1-д заасан хугацаанд багтаан энэ хуулийн 32.2.3-32.2.7-д заасан баримт бичиг болон дэмжигч- сонгуулийн эрх бүхий иргэдийн гарын үсэг бүхий маягт, нэр дэвшүүлснээ илэрхийлсэн мэдэгдлийн хамт тойргийн хороонд ирүүлнэ.

32.4.Энэ хуулийн 32.2.4-т заасан өр төлбөрийн тухай тодорхойлолтыг Улсын дээд шүүх, 32.2.5-д заасан тодорхойлолтыг цагдаагийн төв байгууллага нэр дэвшигч тус бүрээр гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд албан бичгээр хүргүүлнэ.

32.5.Энэ хуулийн 32.2.3, 32.2.4, 32.2.7, 32.3-т заасан баримт бичгийн загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

32.6.Нам, эвсэл нь энэ хуулийн 32.2-т заасан нэр дэвшигчдийн баримт бичгийг тойргийн хороонд хүргүүлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлсэн шийдвэр, нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалт, нэр дэвшүүлсэн тухай хуралдааны тэмдэглэлийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн байна.

32.7.Тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэхдээ нам, эвсэл болон нэр дэвшигчийн ирүүлсэн баримт бичиг үнэн зөв, гүйцэд эсэх, нэр дэвшүүлэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан эсэхийг нягтлан шалгана.

32.8.Бие даан нэр дэвшигчийг дэмжсэн сонгуулийн эрх бүхий дэмжигчдийн гарын үсэг үнэн зөв эсэхийг тойргийн хороо сонгогчийн иргэний үнэмлэх, оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй тулгах буюу шаардлагатай бол тухайн иргэнтэй уулзаж нягтлан шалгах бөгөөд уг ажлыг салбар хороо болон сонгуулийн анхан шатны хороогоор гүйцэтгүүлж болно.

32.9.Тойргийн хороо энэ хуулийн 32.2, 32.3-т заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвшигчээр бүртгэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

32.10.Дараахь тохиолдолд тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзана:

32.10.1.энэ хуулийн 28.1-д заасан хугацаанд нэр дэвшүүлэх ажиллагааг явуулаагүй;

32.10.2.энэ хуулийн 28.3-т заасныг зөрчиж нэр дэвшсэн;

32.10.3.энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан нэр дэвшигчид тавих шаардлагыг хангаагүй;

32.10.4.энэ хуулийн 28.4-т заасныг зөрчиж, өөр намын гишүүнийг нэр дэвшүүлсэн;

32.10.5.нэр дэвшүүлэх ажиллагаа энэ хуулийн 30 дугаар зүйлд заасныг зөрчиж явагдсан бол нийт нэр дэвшигчийг;

32.10.6.энэ хуулийн 32.2-т заасан баримт бичиг дутуу, эсхүл хуурамч бол;

32.10.7.бие даан нэр дэвшигч нь энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан журам зөрчсөн, түүнчлэн дэмжигч- сонгуулийн эрх бүхий иргэдийн гарын үсгийг

цуглуулахдаа бусдыг төлөөлүүлэх, хүч хэрэглэх, хуурч мэхлэх, заналхийлэх, эд мөнгөөр татах, сонгуулийн эрхгүй этгээдээр гарын үсэг зуруулах, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус арга хэрэглэсэн, эсхүл Сонгуулийн ерөнхий хорооноос баталснаас өөр маягтаар гарын үсэг цуглуулсан.

32.11.Энэ хуулийн 32.10-т заасан үндэслэл байхгүй бол тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэр гаргана.

32.12.Тойргийн хороо бүртгэгдсэн нэр дэвшигчид нэр дэвшигчийн үнэмлэх олгоно.

32.13.Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ хуулийн 33.4-т заасан хугацааны дотор зөрчлийг арилгасны үндсэн дээр урьд нь нэр дэвшигчийг бүртгүүлэх хүсэлтээ дахин уламжлах, эсхүл энэ хуульд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлж болно.

32.14.Нэр дэвшигчийг бүртгэх хугацаа дууссанаас хойш тойргийн хороо нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ ажлын таван өдрийн дотор Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

32.15.Сонгуулийн ерөнхий хороо ажлын зургаан өдрийн дотор нийт нэр дэвшигчийн нэрийн жагсаалтыг тойрог, улсын хэмжээгээр нэгтгэж, нийтэд мэдээлнэ.

32.16.Энэ хуулийн 32.2, 32.3-т заасан баримт бичгийг хуурамчаар үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол, эсхүл энэ хуулийн 32.10-т заасан үндэслэл нэр дэвшигч бүртгэгдсэний дараа тогтоогдсон бол нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

32.17.Энэ хуулийн 32.10-т заасан зөрчил байгааг мэдсэн атлаа нэр дэвшигчийг бүртгэсэн буруутай этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

### **33 дугаар зүйл.Нэр дэвшигч татгалзах, нэр дэвшигчийг татан гаргах**

33.1.Энэ хуулийн 32.11, 32.12-т заасны дагуу бүртгэгдэж, үнэмлэх авсан бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах, эсхүл нам, эвсэл нь өөрийн нэр дэвшигчийг татан гаргах, түүний оронд өөр хүний нэрийг дэвшүүлэх эрхтэй.

33.2.Бие даан нэр дэвшигч өөрөө татгалзах буюу нам, эвсэл нэр дэвшигчээ татан гаргах тухай шийдвэрээ тойргийн хороонд нэн даруй хүргүүлнэ.

33.3.Тойргийн хороо энэ хуулийн 33.2-т заасан шийдвэрийг хүлээн авмагц тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрээ хүчингүйд тооцсон тухай шийдвэр гаргаж, энэ тухай Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэх бөгөөд тэрээр нийтэд мэдээлнэ.

33.4.Нам, эвсэл нэр дэвшигчээ татан гаргасан шийдвэрээ сонгуулийн өдрөөс 10 хоногийн өмнө тойргийн хороонд ирүүлээгүй бол татгалзсан болон татан гаргасан нэр дэвшигчийн оронд өөр хүний нэр дэвшүүлэх эрхгүй.

33.5.Саналын хуудас хэвлэгдсэний дараа бие даан нэр дэвшигч өөрөө татгалзсан, эсхүл нам, эвсэл нэр дэвшигчээ татан гаргасан бол энэ тухайгаа Сонгуулийн ерөнхий хороонд мэдэгдэх ба саналын хуудсыг дахин хэвлэхэд гарах зардлыг уг этгээдээс гаргуулна.

#### **34 дүгээр зүйл.Нөхөн нэр дэвшүүлэх**

34.1.Энэ хуулийн 33.4-т заасан хугацааны өмнө нам, эвсэл нэр дэвшигчээ татан гаргасан, нам, эвслээс нэр дэвшигч нас барсан, хүндээр өвчилсөн, гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан, захиргааны журмаар баривчлагдсан, шүүхээр ял шийтгүүлсэн тохиолдолд тухайн нам, эвсэл өөр хүний нэрийг нөхөн дэвшүүлж, сонгуулийн өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан журмын дагуу бүртгүүлж болно.

#### **35 дугаар зүйл.Нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах**

35.1.Нэр дэвшигч энэ хуулийн 32.11, 32.12-т заасны дагуу бүртгүүлж, 32.15-д заасны дагуу нийтэд зарлагдсаны дараа түүнийг нэр дэвшигчийн жагсаалтаас хасах талаархи энэ хуульд заасан үндэслэл тогтоогдвол Сонгуулийн ерөнхий хороо энэ тухай шийдвэр гаргаж, нийтэд мэдээлнэ.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийн талаар маргаан гарвал энэ хуулийн Арванхоёрдугаар бүлэгт заасан харьяалал, журмын дагуу шийдвэрлэнэ.

#### **36 дугаар зүйл. Нэр дэвшигчид туслах**

36.1.Нэр дэвшигчээс сонгогчидтойгоо уулзах, нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зэргээр сонгуульд оролцох бүхий л ажилд нь тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч тус тус тусална.

36.2.Тойргийн хороо 200 сонгогч тутамд нэгээс илүүгүй байхаар тооцож нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагчийг бүртгэж, үнэмлэх олгоно.

36.3.Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч нь сонгуулийн аль нэг хорооны гишүүн байхыг хориглоно.

### **37 дугаар зүйл.Нэр дэвшигчийн үйл ажиллагааны баталгаа**

37.1.Нам, эвсэл болон нэр дэвшигч нь хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сонгуулийн мөрийн хөтөлбөрөө тайлбарлах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ухуулга хийх, үүнтэй холбогдуулан тойргийнхоо холбогдох байгууллагаас зохих журмын дагуу шаардлагатай мэдээлэл, лавлагаа авах эрх эдэлнэ.

37.2.Гэмт үйлдлийнх нь явцад хойшлуулшгүй баривчлахаас бусад тохиолдолд нэр дэвшигчийг тойргийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах, цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл ногдуулах, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл, биед нь үзлэг, нэгжлэг хийх, түүнчлэн захиргааны санаачилгаар ажлаас халахыг хориглоно.

37.3.Нэр дэвшигчийг гүтгэх, доромжлох, нэр төрийг нь гутаах, түүний хувийн болон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасныг зөрчсөн төрийн албан хаагчид Цагдаагийн байгууллагын тухай, Прокурорын байгууллагын тухай, Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулна.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР, СОНГУУЛИЙН ӨМНӨХ УХУУЛГА**

### **38 дугаар зүйл.Сонгуулийн мөрийн хөтөлбөр**

38.1.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

38.2.Улсын Их Хурлын тухайн сонгуульд олонхи суудал авсан нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болно.

38.3.Нам, эвслийн нэр дэвшигч нь тухайн нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс өөр бие даасан мөрийн хөтөлбөртэй байхыг хориглоно.

38.4.Энэ хуулийн 38.3-т заасныг зөрчсөн нэр дэвшигчийг тойргийн хороо намын нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасна.

### **39 дүгээр зүйл.Сонгуулийн өмнөх ухуулга**

39.1.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн өмнөх ухуулгыг нэр дэвшигч энэ хуулийн 32.11, 32.12-т заасны дагуу бүртгүүлж, үнэмлэх авсан өдрөөс эхлүүлнэ.

39.2.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөр, үзэл баримтлалаа тайлбарлан таниулах, нэр дэвшигчийг дэмжин ухуулах ажлыг уулзалт, хурал, цуглаан хийх, ухуулах байр ажиллуулах зэрэг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр зохион байгуулах эрхтэй.

39.3.Сонгуулийн өмнөх ухуулгыг сонгуулийн өдрөөс 24 цагийн өмнө буюу сонгуулийн өдрийн өмнөх өдрийн 00 цагт зогсооно.

39.4.Нэг тойрогт нэг намын жагсаалтаар нэр дэвшигчдийн сонгуулийн өмнөх ухуулгыг тухайн нам нийт нэр дэвшигчдийн өмнөөс бүхэлд нь эрхлэн явуулах ба үүний тулд тойрог бүрт ухуулгын баг байгуулж Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлэн үнэмлэх авч ажиллуулна.

39.5.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан тус бүр хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, буюу товхимол, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад мэдээллийг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.

39.6.Энэ хуулийн 39.5-д заасан хязгаарлалтын дүнг хэвлэмэл байдлаар сонгогчдод тараах бүх төрлийн хэвлэлийн нийлбэрээр тооцно.

39.7.Уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлал зэргийг гудамж, талбай болон олон нийтийн газарт байрлуулах байршлыг сонгуулийн жилийн дөрөвдүгээр сарын нэгний дотор тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид тогтооно.

39.8.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз нь Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон хуваарийн дагуу ухуулгатай холбогдсон нэвтрүүлгийг зөвхөн төлбөргүй явуулах ба төлбөртэй явуулахыг хориглоно.

39.9.Сонгуулийн ерөнхий хороо нь Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээр төлбөргүй явуулах ухуулгын хуваарийг батлахдаа нам, эвсэл бүрт, түүнчлэн нэг тойрогт өрсөлдөж байгаа бие даан нэр дэвшигч бүрт тэнцүү хугацаа ногдохоор тооцож, холбогдох шийдвэр гаргаж мөрдүүлнэ.

39.10.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сонгуулийн өмнөх ухуулгын нэвтрүүлгийг төлбөртэй явуулах бөгөөд ухуулгын төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа тухайн радио, телевизийн нэвтрүүлгийн нийт хугацааны 10 хувиас хэтрэхгүй байна.

39.11.Энэ хуулийн 39.10-т заасан радио, телевиз нь сонгуулийн өмнөх ухуулгыг явуулахдаа энэ хуулийн 39.9-д заасан зарчмыг удирдлага болгоно.

39.12.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тойргийн хороонд бүртгүүлсэн энэ хуулийн 39.1-д заасан өдрөөс мөн хуулийн 39.3-т зааснаар сонгуулийн өмнөх ухуулгыг зогсоох хүртэлх хугацаанд сонгогчидтой уулзалт хийх эрхтэй.

39.13.Хэрэв намын нэрийн жагсаалтад орсон нэр дэвшигч дангаараа сонгуулийн өмнөх ухуулга, уулзалт хийх бол зөвхөн нийт нэр дэвшигчдийнхээ өмнөөс намынхаа мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж оролцох бөгөөд өөрсдийгөө дагнан сурталчлахыг хориглоно.

39.14.Тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга нь нам, эвсэл, нэр дэвшигчдэд уулзалт зохион байгуулахад тэгш хандаж дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

39.15.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь нам, эвсэл, нэр дэвшигчийн уулзалтад зориулж соёлын төв, биеийн тамирын болон хурлын танхим, өрөө, тасалгааг төлбөргүйгээр ашиглуулна.

#### **40 дүгээр зүйл. Сонгуулийн өмнөх ухуулгад хориглох зүйл**

40.1.Сонгуулийн өмнөх ухуулгад дараахь үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

40.1.1.сонгууль зарласнаас хойш нэр дэвшигчийг бүртгэж, үнэмлэх олгох хүртэлх хугацаанд сонгуулийн өмнөх ухуулгыг аливаа хэлбэрээр явуулах;

40.1.2.энэ хуулийн 39.3-т заасан хугацаанаас хойш санал хурааж дуустал аливаа хэлбэрээр ухуулга хийх, түүнчлэн сонгуулийн өдөр хүртэлх долоо хоногийн хугацаанд санал асуулга явуулах, дүнг хэвлэн нийтлэх, тараах;

40.1.3.Эх үүсвэр, хэмжээ, зориулалт нь батлагдаагүй Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгийг иргэдэд тараан олгох, шууд зарцуулахтай холбогдсон амлалтыг нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгах, амаар болон өөр хэлбэрээр сонгогчдын дунд түгээн дэлгэрүүлэх;

40.1.4.нам, эвслээс нэр дэвшигч нь нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн өмнөх ухуулгад ашиглах;

40.1.5.нэр дэвшсэн тойрогт төрийн болон бусад өмчийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын чанартай ажил, үйлчилгээ явуулах;

40.1.6.энэ хуулийн 39.5-д заасан хэмжээнээс илүү хэвлэмэл, мэдээлэл тараах;

40.1.7.уриалга, ухуулах болон зурагт хуудас, зарлалыг барилгын хана, орц, хашаа, гэрлийн шон зэрэг энэ хуулийн 39.7-д зааснаас өөр газарт байрлуулах;

40.1.8.энэ хуулийн 39.9-39.13-т заасныг зөрчиж ухуулга явуулах;

40.1.9.оройн 23 цагаас дараа өдрийн 10 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах;

40.1.10.сонгуульд оролцохоос татгалзах, сонгуулийн болон бусад хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий ухуулга хийх;

40.1.11.шашны зан үйл ашиглах;

40.1.12.сонгогч, түүний гэр бүл, насанд хүрээгүй хүүхэд, байгууллага, хамт олонд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, мөнгө, эм тариа, хүнсний болон бусад эд бараа төлбөргүй тараах, хөнгөлөлттэй үнээр худалдах;

40.1.13.төлбөргүйгээр буюу хөнгөлөлттэй үнээр ахуйн болон эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үзлэг явуулах;

40.1.14.биеийн тамир, спортын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, төлбөрт таавар, бооцоот болон мөрийтэй тоглоом зохион байгуулах;

40.1.15.сонгогчдын саналыг татах зорилгоор хүлээн авалт, дайллага, цайллага, сонгуулийн бус олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах;

40.1.16.төрийн байгууллага, түүнчлэн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг төлбөртэй буюу төлбөргүйгээр ухуулгын материал хэвлэх, олшруулах, тээвэрлэх зэргээр сонгуулийн өмнөх ухуулгад аливаа хэлбэрээр ашиглах;

40.1.17.сонгуулийн өмнөх ухуулгад төрийн жинхэнэ албан хаагч болон насанд хүрээгүй хүүхдийг аливаа хэлбэрээр татан оролцуулах;

40.1.18.сонгогчдын санал худалдан авахад чиглэсэн бусад аливаа үйлдэл, үйл ажиллагаа явуулах.

40.2.Нам, эвсэл, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч нь сонгуулийн өмнөх ухуулгад аливаа шашны сургаал, жаяг дэгийн дагуу үйлддэг хурал хуруулах, сан тавиулах, майдар эргэх, жасаа уншуулах, даллага авахуулах, тахилга мөргөл үйлдүүлэх, овоо тахих үйлдэл, үйл ажиллагааг зохион байгуулсан, түүнд оролцсон, ийм арга хэмжээг санхүүжүүлсэн, шашны эд өглөгийн зүйл, хэрэгсэл тараасан бол шашны зан үйл ашигласан гэж үзнэ.

40.3.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч өөрийн мөрийн хөтөлбөрт тусгасан иргэдийн шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр, сүм хийдийн харилцаа, шашны талаархи бодлого, үзэл баримтлалыг сонгогчдод тайлбарлан таниулсныг энэ хуулийн 40.2-т заасан үйлдэл гэж үзэхгүй.

40.4.Дараахь газруудад сонгуулийн өмнөх ухуулга хийхийг хориглоно:

40.4.1.төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

40.4.2.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой байгууллага, аж ахуйн нэгж;

40.4.3.хүмүүнлэгийн, буяны болон шашны байгууллага;

40.4.4.сонгуулийн хороод.

40.5.Энэ хуулийн 40.4.1, 40.4.2 дахь заалт нь мөн хуулийн 39.15-д үл хамаарна.

40.6.Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн өмнөх ухуулгын тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавьж, энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, байгууллага, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэнэ.

40.7.Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулахаар улсын төсвөөс Улс төрийн намын тухай хуулийн 19.2-т заасны дагуу олгосон санхүүжилтийг сонгууль зарласнаас хойш сонгуулийн дүн эцэслэн гаргах хүртэл хугацаанд хэрэглэхийг хориглоно.

40.9.Энэ хуулийн 40.1.1, 40.1.2, 40.1.12-40.1.17-д заасан зөрчил гаргасан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах бөгөөд хэрэв зөрчил нь ноцтой бол зохих хороо нь хуулийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ СОНГУУЛИЙН ЗАРДАЛ**

### **41 дүгээр зүйл. Сонгуулийн зардал**

41.1. Сонгуулийн зардлын зохих хэсгийг энэ хуулийн 10.1-д заасан журмаар улсын төсвөөс санхүүжүүлэх бөгөөд нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн зардлыг тухайн нам, эвсэл болон нэр дэвшигч, харин бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлаа өөрөө тус тус хариуцна.

41.2. Нэг нам, эвсэл, нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, байршил зэргийг харгалзан Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний дотор тойрог тус бүрээр тогтооно.

### **42 дугаар зүйл. Сонгуулийн зардлын данс**

42.1. Нам, эвсэл нь өөрийн нэр дээр болон нэг тойрогт нам, эвслийн нэрийн жагсаалтаар нэр дэвшигчдийн дунд сонгуулийн зардлын нэг дансыг тус тус Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор, түүнчлэн бие даан нэр дэвшигч нь өөрийн сонгуулийн зардлын дансыг тойргийн хороонд бүртгүүлснээс хойш гурав хоногийн дотор тус тус банкинд нээлгэж, энэ тухай Сонгуулийн ерөнхий хороонд албан ёсоор мэдэгдэж, нийтэд зарлана.

42.2. Нам, эвслийн дансны төлөвлөгөөг Сонгуулийн ерөнхий хороо санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанкт хамтран баталж, энэ хуулийн 42.1-д заасны дагуу дансаа нээлгэх ба үүнээс өөр данс нээлгэхийг хориглоно.

42.3. Энэ хуулийн 42.1-д заасан дансанд нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, дэмжигч байгууллага, иргэдээс оруулсан хандивыг төвлөрүүлж, мөн дансаар дамжуулан зориулалтаар нь зарцуулна.

42.4. Энэ хуулийн 41.1-д заасан дансанд төвлөрсөн хөрөнгийг нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах, нэр дэвшигч, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, шадар туслагчийн бичиг хэрэг, шуудан,

холбоо, унааны болон албан томилолт, хөлс, урамшуулал зэрэг төсөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

42.5.Энэ хуулийн 42.3, 42.4-т заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах ба мөн хуулийн 42.1-д заасан данснаас гадуур өгсөн, 42.2-т заасныг зөрчиж нээлгэсэн дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг хурааж, улсын орлого болгоно.

### **43 дугаар зүйл. Сонгуулийн хандив**

43.1. Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ хувь хүнээс нэг сая төгрөг, хуулийн этгээдээс гурван сая төгрөг хүртэл байж болох бөгөөд түүний хэмжээг нам, эвсэл, нэр дэвшигч бүрт сонгуулийн зардлын дансанд төвлөрсөн хөрөнгийн нийлбэрээр тооцно.

43.2. Мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансаар дамжуулан өгөх ба мөнгөн бус эд хөрөнгийн хэлбэрээр өгсөн хандивыг мөнгөөр үнэлж, энэ хуулийн 43.1-д заасан хандивын дүнд оруулан тус тус тооцно.

43.3. Хуулийн этгээд хандив өгөх асуудлыг түүний Төлөөлөн удирдах зөвлөл буюу түүнтэй адил эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.

43.4. Дараахь этгээдээс хандив авахыг хориглоно:

43.4.1. гадаад улс буюу гадаадын байгууллага /хамтарсан байгууллагын гадаадын оролцогч/;

43.4.2. олон улсын байгууллага;

43.4.3. төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;

43.4.4. гадаад улсын иргэн;

43.4.5. харьяалалгүй хүн;

43.4.6. сонгууль зарласан өдөр 18 насанд хүрээгүй Монгол Улсын иргэн;

43.4.7. төрийн болон орон нутгийн өмчит болон тийм өмчийн оролцоотой хуулийн этгээд;

43.4.8. шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан, банкны хугацаа хэтэрсэн зээлийн өртэй хуулийн этгээд;

43.4.9. Үйлдвэрчний эвлэл, шашны болон бусад төрийн бус байгууллага.

43.4.10. байгуулагдаад нэг жил болоогүй хуулийн этгээд.

43.5.Сонгууль бэлтгэн явуулах хугацаанд гадаад, дотоодын тусламжийн эд хөрөнгийг сонгуулийн аливаа зардалд зориулж зарцуулахыг хориглоно.

43.6.Сонгууль явуулах жил зөвхөн сонгуулийн үйл ажиллагаанд зориулж хандив өгөх бөгөөд энэ тохиолдолд Улс төрийн намын тухай хуулийн 18.3-т заасан хандивыг нам, эвсэлд давхардуулан өгөхийг хориглоно.

43.7.Энэ хуулийн 43.4-т заасан этгээдээс хандив авч зарцуулсан нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах ба мөн хуулийн 43.1-д заасан хэмжээнээс илүү гарсан, түүнчлэн 42.1-д заасан данснаас гадуур өгсөн болон 43.4-т заасан этгээдээс авсан хандивыг хурааж улсын орлого болгоно.

#### **44 дүгээр зүйл.Сонгуулийн санхүүжилтэд тавих захиргааны хяналт, зардлын тайлан гаргах**

44.1.Сонгуулийн ерөнхий хороо, тойргийн хороо нь нам, эвсэл, бие даан нэр дэвшигчээс Сонгуулийн ерөнхий хорооны баталсан зардлын дээд хэмжээг баримталж, хөрөнгө, хандивыг сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулж байгаад хяналт тавьж иргэдийн мэдээлэл болон өөрсдийн санаачилгаар аудит хийлгэх буюу өөрийн дэргэдэх Сонгуулийн санхүүгийн хянан байцаах хэлтэсээр гэнэтийн болон төлөвлөгөөт баримтын шалгалт хийлгэж зөрчил, гажуудлыг цаг тухайд нь арилгуулах арга хэмжээ авч байна.

44.2.Сонгуулийн ерөнхий хорооны дэргэд Улсын Их Хурлаас баталсан орон тоонд багтаан дараахь эрх бүхий Сонгуулийн санхүүгийн хянан байцаах хэлтэс ажиллана:

44.2.1.нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн зардлын дансыг банкинд цаг тухайд нь нээж, гүйлгээг үнэн зөв хөтөлж байгааг хянан шалгах;

44.2.2.иргэд, хуулийн этгээдээс хандив авах хэмжээг хэрхэн сахиж, түүнийг дансанд төвлөрүүлж зарцуулах, эд хөрөнгийн хандивыг зохих ёсоор үнэлж дансанд тусгаж байгаа байдлыг хянан шалгах;

44.2.3.Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан тойрог бүрт ногдуулсан зардлын хэмжээг сахиж, хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, тайлангаа баримтжуулж байгааг хянан шалгах;

44.2.4.сонгуулийн зардлын тайланг үнэн зөв гаргаж байгаа эсэхийг хянан шалгах;

44.2.5.энэ хуулийн 44.2.1-44.2.4-т заасан хяналт шалгалтын дүнг нэгтгэн зохих акт үйлдэж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

44.3.Сонгуулийн санхүүгийн хянан байцаах хэлтэс нь баримтын шалгалт хийхдээ Монголбанкны санхүүгийн хянан байцаах албаны байцаагчийн эрхийг эдэлнэ.

44.4.Сонгуулийн санхүүгийн хянан байцаах хэлтсийн шалгалтын актаар тавигдсан төлбөр, үүргийг нам, эвсэл, нэр дэвшигч биелүүлэх үүрэгтэй.

44.5.Сонгуулийн зардлын дансанд мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, түүнийг зарцуулах тухай тайлангийн загвар болон данс нээх, хаах, бүртгэл, тайланг хөтлөх журмыг Сонгуулийн ерөнхий хороо Монголбанкт хамтран батална.

44.6.Нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн зардлын явцын тайланг Сонгуулийн ерөнхий хорооны шаардлагаар гарган өгөх ба эцсийн тайланг санал хурааж дууссан өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж, Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

44.7.Нам, эвсэл энэ хуулийн 44.8-т заасан сонгуулийн зардлын тайлан /цаашид “зардлын тайлан” гэх/-даа аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсан байна.

44.8.Сонгуулийн зардлын тайланг дараахь үзүүлэлтээр гаргана:

44.8.1.санд төвлөрүүлсэн орлого, нийт хандивын хэмжээ;

44.8.2.орлогын эх үүсвэр, түүний дотор хандивын төрөл, хэмжээ;

44.8.3.хандивлагч иргэний овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, банкны гүйлгээ хийсэн баримт, хандивын хэмжээ, хэлбэр;

44.8.4.хандивлагч хуулийн этгээдийн нэр, оршин байгаа газрын хаяг, гүйцэтгэх захирлын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хандивын хэмжээ, хэлбэр;

44.8.5.зарлагын ангилал, гүйцэтгэл;

44.8.6.үлдэгдлийн хэмжээ, байршил.

44.9.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс барьж буй банкны захирал нь уг дансны бүх хөдөлгөөнийг нэгтгэсэн тайлан гаргаж, энэ хуулийн 44.6-т заасан хугацаанд Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

44.10.Сонгуулийн өдрөөс хойш зардлын тайланг гаргах хүртэлх хугацаанд энэ хуулийн 42.1-д заасан дансанд аливаа хөдөлгөөн хийхийг хориглоно.

44.11.Сонгуулийн ерөнхий хороо зардлын тайланг хянан үзэж, санал хурааж дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба хоёр зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван зуун мянга, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана.

44.12.Энэ хуулийн 44.10-д заасан хугацаанд хийсэн гүйлгээтэй тэнцэх хэмжээний хөрөнгийг банкны өөрийнх нь хөрөнгөөс гаргуулж, улсын орлого болгоно.

## **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ**

### **45 дугаар зүйл. Санал авах газар, хугацаа**

45.1.Сонгогчдын саналыг санал авах өдрийн 07 цагаас 24 цаг хүртэл хугацаанд сонгуулийн хэсгийн байранд авна.

45.2.Сонгогчдын сонгуулийн өдөр, цаг, байрыг хэсгийн хороо, баг, хорооны Засаг дарга уул өдөр хүртэлх 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлнэ.

45.3.Сонгогчдоос саналаа нууцаар өгөхөд шаардагдах тооны бүхээг, саналын хайрцаг бүхий байрыг сонгуулийн өдрөөс долоо хоногийн өмнө тухайн хэсгийн харьяалагдах сум, дүүргийн Засаг дарга хариуцан бэлтгүүлнэ.

45.4.Энэ хуулийн 45.3-т заасан бүхээгийн хэмжээ, загварыг Сонгуулийн ерөнхий хороо батална.

45.5.Санал авах байранд нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч байрлахыг хориглоно.

### **46 дугаар зүйл. Саналын хуудас, түүнийг бэлтгэх**

46.1.Саналын хуудас нь сонгогчоос саналаа нууцаар тэмдэглэн илэрхийлэх, сонгуулийн дүнг тоолж гаргах хууль зүйн үндсэн баримт бичиг мөн.

46.2.Сонгуулийн ерөнхий хороо саналын хуудасны загвар, тоо, түүнийг хэвлүүлэх, хадгалах, хүргүүлэх, хамгаалах журам болон тэдгээрт тавих шаардлагыг сонгуулийн өдрөөс 30 хоногийн өмнө батална.

46.3.Саналын хуудас нь тусгай нууцлалтай, нэгдсэн таних нууц тэмдэг /бар код/-тэй байна.

46.4.Саналын хуудсыг Сонгуулийн ерөнхий хороо эрхлэн хэвлүүлж, тойргийн хороонд, тойргийн хороо нь салбар хороогоор дамжуулан сонгуулийн өдрөөс тав хоногийн өмнө хэсгийн хороонд тус тус хүргүүлж албан ёсоор хүлээлгэн өгнө.

46.5.Саналын хуудсанд сонгуульд оролцож байгаа нам, эвслийн нэр, тухайн нам, эвслээс нэр дэвшигчдийн болон бие даан нэр дэвшигчийн өөрийн нь нэр болон овог, эцэг /эх/-ийн нэрийг бичнэ.

46.6.Саналын хуудас нь хэвтээ хүснэгтийн хэлбэртэй байх бөгөөд хүснэгтэд дараахь мэдээллийг тэмдэглэсэн байна:

46.6.1.нам, эвслийн дэс дугаар;

46.6.2.нам, эвслийн бүртгэгдсэн нэр;

46.6.3.нам, эвслээс нэр дэвшигчдийн дэс дугаар, өөрийн нь нэр болон овог, эцэг /эх/-ийн нэр;

46.6.4.бие даан нэр дэвшигчдийн дэс дугаар;

46.6.5.бие даан нэр дэвшигчдийн өөрийн нь нэр болон овог, эцэг /эх/-ийн нэр.

46.7.Саналын хуудсанд нам, эвслийн нэрийг Улсын Их Хурлын өмнөх сонгуульд авсан суудал, саналын тооны ихээс бага руу жагсааж, сонгуульд оролцоогүй намыг Улсын дээд шүүхэд /улсын бүртгэлд/ бүртгүүлсэн дарааллаар бичнэ.

46.8.Энэ хуулийн 46.6.3-т заасан нам, эвслээс нэр дэвшигчдийн нэрийг тухайн нам, эвслээс ирүүлсэн дарааллаар дугаарлан бичнэ.

46.9.Саналын хуудсанд бие даан нэр дэвшигчийн нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар бичнэ.

46.10.Саналын хуудсанд тухайн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, хэсгийн хорооны тэмдэг дарах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглоно.

46.11.Сонгуулийн хороод саналын хуудсыг бүрэлдэхүүнээрээ хүлээн авч, энэ тухай тэмдэглэл хөтөлж, байлцсан бүх гишүүн гарын үсэг зурна.

46.12.Сонгуулийн хорооны аль нэг гишүүн энэ хуулийн 46.11-т заасан тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал шалтгаан, үндэслэлээ бичгээр үйлдэж, холбогдох сонгуулийн хороонд өгнө.

46.13.Сонгогчид саналын хүчингүй хуудас олгосон буруутай этгээдийг сонгуулийн хорооны бүрэлдэхүүнээс хасна.

#### **47 дугаар зүйл.Санал авах журам**

47.1.Сонгуулийн өдрийн 07 цагт хэсгийн хорооны бүрэлдэхүүн сонгогчдын төлөөллийг байлцуулан санал авах бүх хайрцгийг нээж харуулан, шалган битүүмжилж лацдсаны дараа хэсгийн хорооны дарга дараахь мэдээлэл хийнэ:

47.1.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, үүнээс өөр тойрог, хэсэгт шилжиж явсан, саналаа урьдчилан өгсөн, нас барсан зэргээр хасагдсан, мөн шилжин ирсэн сонгогчийн тоо;

47.1.2.саналаа өгвөл зохих нийт сонгогчийн тоо, үүнээс саналын байранд ирж саналаа өгөх сонгогчийн тоо, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар саналаа өгөх сонгогчийн тоо;

47.1.3.хүлээн авсан, урьдчилан санал авахад олгосон, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн саналын хуудасны тоо;

47.1.4.урьдчилан санал өгсөн сонгогчдын тоо, түүний явцад буруу тэмдэглэл хийснээс хүчингүй болсон саналын хуудасны тоо;

47.1.5.санал авах зөөврийн битүүмжилсэн хайрцгийн тоо, түүгээр санал өгөх сонгогчийн тоо, санал авах хуваарь;

47.1.6.хүлээн авсан, тараасан, буруу бичсэнээс хүчингүй болсон, алдагдаж үрэгдсэн, утсан, үлдсэн сонгогчийн үнэмлэхийн тоо.

47.2.Энэ хуулийн 47.1.4-т заасан урьдчилан өгсөн саналын тоог тусгайлан тэмдэглэж, тэдгээр саналын хуудсыг битүүмжилсэн дугтуйтай нь санал авах хайрцагт хийнэ.

47.3.Энэ хуулийн 47.1, 47.2-т заасан ажиллагаа, мэдээллийг нэг бүрчлэн тусгасан тэмдэглэл хөтөлж хэсгийн хорооны бүх гишүүн гарын үсэг зурна.

47.4.Хэсгийн хороо энэ хуулийн 47.1-47.3-т заасан ажиллагааг гүйцэтгэсний дараа санал хураалтыг эхлүүлэх ба ингэхдээ сонгогчийн үнэмлэх, иргэний үнэмлэхийг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэж, сонгогч бүрт саналын хуудас олгоно.

47.5.Саналын хуудас авсан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсгээ зурна.

47.6.Саналаа өгсөн иргэний сонгогчийн үнэмлэхэд тусгайлан үүрэг хүлээсэн хэсгийн хорооны гишүүн тэмдэглэл хийж, хэсгийн хорооны тэмдэг дарах бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон тусгай тэмдэглэл хэрэглэж болно.

47.7.Санал авах ажиллагаанд нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн томилсон ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.

47.8.Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд саналаа өгөхөөс бусад үед байхыг хориглоно.

## **48 дугаар зүйл. Сонгуулийн ажиглагч**

48.1.Нам, эвсэл, бие даан нэр дэвшигч өөрийн ажиглагчийг томилж сонгуулийн өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд бүртгүүлж, үнэмлэх авахуулна.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан хугацаа өнгөрсөн бол ажиглагч ажиллуулах, бүртгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авахгүй.

48.3.Ажиглагч нь сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх,сонгогчийн үнэмлэх бичих, санал авах, тоолох, дүн гаргах үед уг ажлыг сонгуулийн хууль тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг хөндлөнгөөс ажиглан хянахдаа дараахь эрх эдэлнэ:

48.3.1.нам, эвслийн болон сонгогчдын нэрийн жагсаалттай танилцах;

48.3.2.саналын хуудасны битүүмжлэгдсэн байдалтай танилцах;

48.3.3.санал тоолох ажлыг ажиглах;

48.3.4.бие даан нэр дэвшигчийн дэмжигч-сонгуулийн эрх бүхий иргэдээс цуглуулсан гарын үсэг, маягттай танилцах;

48.3.5.урьдчилан санал авах үйл ажиллагааг ажиглах;

48.3.6.зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах сонгогчдын нэрийн жагсаалт, тэднээс санал авах чиглэл, хуваарьтай танилцах;

48.3.7.санал өгөх бүхээг, саналын хайрцаг болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;

48.3.8.санал авах байранд сонгуулийн санал авах үйл явцыг бүхэлд нь ажиглаж болохуйц суудалтай байх;

48.3.9.санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хорооны даргад мэдэгдэж, залруулахыг хүсэх, илэрсэн зөрчлийн талаар тэмдэглэл хөтлөх, дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан баталгаажуулах, гэрчээр гарын үсэг зуруулах;

48.3.10.хэсгийн хорооны гишүүдээс холбогдох мэдээлэл авах;

48.3.11.ажиглалтын тайлангаа нийтэд тавих, хэвлэн нийтлэх.

48.4.Ажиглагч энэ хуулийн 48.3-т заагаагүй эрх эдлэхийг оролдох, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал, хуурамч мэдээлэл олон нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэж, сонгуулийн хороодын ажилд хөндлөнгөөс оролцвол хэсгийн хороо түүний ажиглагчийн эрхийг хүчингүй болгож, үнэмлэхийг хураан авна.

48.5.Ажиглагч энэ хуулийн 48.4-т заасны дагуу эрхээ хасуулсан бол түүнийг санал болгосон нам, эвсэл, нэр дэвшигч нь орны хүнийг томилох эрхгүй бөгөөд ийм хүсэлт гаргавал сонгуулийн хороод хүлээн авахаас татгалзана.

48.6.Гадаадын ажиглагч, түүнчлэн аливаа хэвлэл, мэдээллийн байгууллага, ажилтан сонгуулийг ажиглах, сурвалжлах, мэдээлэхтэй холбогдсон журмыг Сонгуулийн ерөнхий хороо баталж мөрдүүлнэ.

48.7.Нам, эвсэл, нэр дэвшигчээс өөр аливаа этгээд ажиглагч томилох, ажиллуулах эрхгүй бөгөөд энэ заалт энэ хуулийн 48.6 дахь заалтад хамаарахгүй.

## **49 дүгээр зүйл. Сонгогч саналаа өгөх**

49.1. Сонгогч санал авах байранд ирж, саналаа өөрөө биечлэн өгнө.

49.2. Сонгогч бүр саналын нэг хуудас авч, санал бэлтгэх бүхээгт орж, саналаа нууцаар өгнө.

49.3. Сонгогч нь саналын хуудсанд бичигдсэн, өөрийн сонгохыг хүссэн нэг нам, эвслийн нэрийн өмнөх дугаарыг тэр нам буюу эвслээс нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас өөрийнхөө дэмжиж байгаа зөвхөн нэг нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарын хамт тус тус, эсхүл нэг бие даан нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаарыг дугуйлж, саналын хуудсыг хайрцагт хийнэ.

49.4. Сонгогч санал өгөхдөө алдаа гаргаж, саналын хуудсанд буруу тэмдэглэл хийсэн бол энэ тухайгаа саналын хуудсаа хайрцагт хийхээс өмнө хэсгийн хороонд мэдэгдэж, алдаатай хуудсыг шалгуулан хураалгаж, дахин нэг удаа саналын хуудас авч, энэ хуулийн 49.3-т заасны дагуу санал өгч болно.

49.5. Хэсгийн хороо энэ хуулийн 49.4-т заасны дагуу хураалгасан саналын хуудсыг тэмдэглэл хөтлөн хадгална.

49.6. Санал бэлтгэх бүхээгт тухайн сонгогчоос өөр хүн байхыг хориглоно.

49.7. Бие эрхтэний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын байдлаас шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүний туслалцаатайгаар санал өгч болох бөгөөд тэр нь сонгуулийн эрх бүхий иргэн байна.

49.8. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагч, сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, ажиглагч нь энэ хуулийн 49.7-д заасан итгэмжлэгдсэн хүн байж болохгүй.

49.9. Хэсгийн хороо нь сонгогчийн саналаа нууцаар өгөх эрхэд халдахгүйгээр санал хураалт хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, зөрчил гарвал таслан зогсоох арга хэмжээ авна.

49.10. Биеийн эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд хүрэлцэн ирж чадахгүй сонгогч зөөврийн битүүмжилсэн хайрцагаар санал өгөх хүсэлтээ сонгуулийн өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд бичгээр гаргана.

49.11. Хэсгийн хороо энэ хуулийн 49.10-т заасан хүсэлтийг үндэслэн зөөврийн битүүмжилсэн хайрцагаар саналыг нь авах сонгогчдын нэрийн жагсаалтыг тусад нь гаргаж, нэрийн жагсаалт, санал авах чиглэл, хуваарийг хуралдаанаараа хэлэлцэн батална.

49.12. Энэ хуулийн 49.11-д заасан сонгогчийн саналыг тухайн хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн оршин суугаа газрын нь хаягаар очиж авна.

49.13.Зөөврийн битүүмжилсэн хайрцгаар энэ хуулийн 49.11-д заасан жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг очиж авахыг хориглоно.

49.14.Хэсгийн хороо саналын хуудас хүлээн авснаас хойш сонгуулийн өдөр хүртэлх хугацаанд сонгогч түр шилжин явахад хүрвэл хэсгийн хороонд ирж, саналаа нууцаар өгч, дугтуйнд хийж битүүмжлэн үлдээж болно.

49.15.Энэ хуулийн 49.14-т зааснаар урьдчилан санал өгөх тохиолдол бүрт хэсгийн хорооны хоёроос доошгүй гишүүн байлцах ба энэ тухай тэмдэглэл хөтөлж, түүнд байлцсан хэсгийн хорооны гишүүн бүр гарын үсэг зурна.

49.16.Хэсгийн хороо сонгогчийн битүүмжлэн үлдээсэн саналын нууцыг чандлан хадгална.

49.17.Энэ хуулийн 49.10, 49.14-т заасан сонгогчийн саналыг авахад энэ хуулийн 49.1-49.5, 49.7, 49.8-д заасан журмыг баримтална.

49.18.Сонгуулийн өдөр ажиллаж байгаа сонгогчид ажлын газрын захиргаа нь чөлөө олгож, түүнийг санал өгөх боломжоор заавал хангах үүрэгтэй.

## **50 дугаар зүйл.Санал тоолох**

50.1.Санал тоолох ажиллагааг сонгуулийн өдрийн 24 цагт эхэлж, ил тод, нээлттэй явуулна.

50.2.Санал тоолоход ажиглагч, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчид байлцаж болно.

50.3.Санал тоолох бэлтгэл хангагдмагц хэсгийн хорооны дарга санал тоолох ажил эхэлснийг зарлан хэсгийн хороо дараахь журмаар ажиллана:

50.3.1.санал өгсөн нийт сонгогчийн тоо санал авахад олгосон саналын хуудасны тоотой тохирч байгаа эсэхийг тулган шалгаж, эцсийн тооцоо гаргах;

50.3.2.санал авахад олгоогүй үлдсэн болон буруу тэмдэглэл хийснээс хураагдсан саналын хуудсыг тус тусад нь тоолж, баруун дээд өнцгийг нь хайчлан, энэ тухай тэмдэглэл хөтөлж, боож битүүмжлэх;

50.3.3.энэ хуулийн 50.3.1, 50.3.2-т заасан ажлыг хийж гүйцэтгэсний дараа саналын хайрцгийг нээж, саналыг тоолох;

50.3.4.санал тоолж дууссаны дараа санал хураалтын дүнг хэсгийн хэмжээгээр гаргах.

50.4.Хэсгийн хороо санал хураалтын дүнг дараахь үзүүлэлтээр гаргана:

50.4.1.сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тухайн хэсгийн нийт сонгогчийн тоо;

50.4.2.санал өгсөн нийт сонгогчийн тоо, үүнээс зөөврийн битүүмжилсэн хайрцгаар болон урьдчилан санал өгсөн сонгогчийн тоо;

50.4.3.саналын хайрцгаас гарсан саналын хүчинтэй, хүчингүй хуудасны тоо;

50.4.4.нам, эвсэл, тухайн нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигч тус бүрийн төлөө өгсөн саналын тоо, хувь.

50.5.Санал авахад олгосон болон олгоогүй үлдсэн саналын хуудасны нийлбэр нь тухайн хэсгийн хороо анх хүлээн авсан нийт саналын хуудасны тооноос зөрвөл хэсгийн хороо шалтгааныг шалгаж тогтоох бөгөөд зайлшгүй шаардлага гарвал саналын хуудсыг нэн даруй дахин тоолно. Алгуурлаж болохгүй.

50.6.Санал тоолох үед энэ хуулийн 50.5-д заасан зөрүү гарвал энэ тухай тэмдэглэл хөтөлж, санал тоолоход оролцогчдоор гарын үсэг зуруулна.

50.7.Санал авахад олгосон саналын хуудасны тоо нь саналын хайрцагнаас гарсан болон энэ хуулийн 50.3.2-т заасны дагуу хураагдсан саналын хуудасны тооны нийлбэртэй тэнцүү байна.

50.8.Санал тоолох цаг болоогүй байхад саналын хайрцаг нээх, нэгэнт эхэлсэн санал тооллогыг завсарлах, саналын хуудасны тооны тэнцлийн зөрүүг нэн даруй зөвтгөн тогтоолгүй орхихыг хориглоно.

50.9.Саналын хуудсанд огт тэмдэглэл хийгээгүй, эсхүл бүх нам, эвсэл болон нэр дэвшигчийн нэрийг бүгдийг дарсан саналын хуудсыг хүчинтэй саналын хуудаст тооцож, аль ч нам, эвсэл, нэр дэвшигчээс хэнийг ч дэмжээгүй санал гэж үзнэ.

50.10.Энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан санал тоолох журам зөрчсөн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргыг зөрчил нь ноцтой бол хорооны бүрэлдэхүүнээс хасна.

## **51 дүгээр зүйл.Саналын хуудсыг хүчингүйд тооцох**

51.1.Хэсгийн хороо дор дурдсан шалтгаан тогтоогдвол саналын хуудсыг хүчингүйд тооцно:

51.1.1. баталсан загварын бус хуудсаар санал өгсөн;

51.1.2. тухайн хэсгийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэггүй, хэсгийн хорооны тэмдэггүй саналын хуудсаар санал өгсөн;

51.1.3. нэгээс илүү нам, эвсэл, эсхүл нэр дэвшигчийн төлөө санал өгсөн, түүнчлэн энэ хуульд зааснаас өөр тэмдэглэл хийсэн;

51.1.4. нам, эвслийн болон бие даан нэр дэвшигчийн нэрийн өмнө тавьсан дугаарыг засварласан;

51.1.5. зөвхөн нэг нам, эвслийн өмнөх дугаарыг дугуйлсан боловч түүний нэг нэр дэвшигчийн өмнөх дугаарыг дугуйлаагүй, түүнчлэн нэг нам, эвслийн нэрийн өмнөх дугаарыг өөр нам, эвслээс нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугаартай, эсхүл бие даан нэр дэвшигчийн өмнөх дугаартай нэгэн зэрэг дугуйлсан.

51.2. Хэсгийн хороо санал тоолж, саналын хуудсыг хүчинтэй, хүчингүйгээр ялгаж дүгнээд хуралдаанаараа хэлэлцэн баталж нийтэд сонсгон, улмаар сонгуулийн анхан шатны хороонд нэг хоногийн дотор хүргүүлнэ.

51.3. Сонгуулийн анхан шатны хороо нь хэсгийн хороодоос ирүүлсэн санал хураалтын дүнг нэг хоногийн дотор сум, нийслэлийн дүүргийнхээ хэмжээгээр нэгтгэн тойргийн салбар хороонд, тойргийн салбар хороо нь анхан шатны хороодоос ирүүлсэн саналын дүнг 2 хоногийн дотор нэгтгэн тойргийн хэмжээнд тус тус хүргүүлнэ.

## **АРАВДУГААР БҮЛЭГ САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭН ГАРГАЖ ГИШҮҮНИЙ МАНДАТ ХУВААРИЛАХ**

### **52 дугаар зүйл. Тойргийн хэмжээнд сонгуулийн санал хураалтын дүнг гаргах**

52.1. Тойргийн хороо санал хураалтын дүнг тав хоногийн дотор гарган хуралдаанаараа хэлэлцэж, Сонгуулийн ерөнхий хороонд хоёр хоногийн дотор мэдээлнэ.

52.2. Тойргийн хороо нь салбар хороодын ирүүлсэн дүн, мэдээг үндэслэн энэ хуулийн 50.4-т заасан үзүүлэлтээр тойргийн хэмжээний санал хураалтын дүнг нэгтгэхийн зэрэгцээ дараахь үзүүлэлтийг тусгайлан тооцож гаргана:

52.2.1. тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын тоо, үүнээс сонгуульд оролцсон сонгогчдын тоо, эзлэх хувь;

52.2.2.сонгогчдод олгосон саналын хүчинтэй хуудасны тоо, эзлэх хувь;  
52.2.3.тойрогт нэр дэвшсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тус бүрийн төлөө тухайн тойргийн нийт сонгогчдын өгсөн саналын тоо;

52.2.4.сонгогчдоос нам, эвсэл бүрийн нэрийн жагсаалтад бичигдсэн нэр дэвшигчдийн төлөө өгсөн саналын тоо.

52.3.Энэ хуулийн 52.2.3, 52.2.4-т заасан саналын тоог зөвхөн саналын хүчинтэй хуудсаар тооцож гаргана.

52.4.Тойргийн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн нийт сонгогчдын ердийн олонхи (50+1) санал хураалтад оролцсон бол тойргийн хэмжээгээр сонгуулийг хүчинтэйд тооцож, дүнг тойргийн хорооны хуралдаанаар хэлэлцэж батална.

52.5.Сонгуулийг хүчинтэйд тооцсон нөхцөлд энэ хуулийн 52.2.3, 52.2.4-т заасан саналын тоог үндэслэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн хооронд Улсын Их Хурлын гишүүний мандатыг хуваарилна.

### **53 дугаар зүйл. Улсын Их Хурлын гишүүний мандат хуваарилах зарчим, журам**

53.1.Тойргийн хороо нь сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн хооронд Улсын Их Хурлын гишүүний мандатыг сонгуулийн босго болон санал хуваагчийг хэрэглэн дор дурдсан журмаар хуваарилна:

53.1.1.сонгуулийн босгыг тойрогт явагдсан сонгуулийн нийт хүчинтэй саналын дүнг тухайн тойрогт ногдсон мандатын тоонд хувааж гаргах;

53.1.2.нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийг авсан нийт хүчинтэй саналын тоог баримтлан хамгийн олон санал авснаас нь эхлэн дараалуулж саналын дүнгийн тооны хамт жагсаах;

53.1.3.нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тус бүрийн авсан нийт саналыг энэ хуулийн 53.1.1-д заасан сонгуулийн босгод хувааж, тэдгээрийн авсан мандатын тоог тодорхойлох;

53.1.4.хуваарилагдсан мандатын тоо нь тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү байвал суудлын тоо гүйцсэнд тооцож, мандат хуваарилагдаагүй нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийг тооцооноос хасах;

53.1.5.хэрэв энэ хуулийн 53.1.3-т зааснаар хуваарилагдсан мандатын тоо нь тойрогт ногдсон мандатын тооноос бага байвал хуваарилагдаагүй үлдсэн мандатыг хамгийн их үлдэгдлийн зарчмыг баримтлан хуваарилах.

53.2.Энэ хуулийн 53.1.5-д заасан үлдсэн мандатыг хамгийн их үлдэгдлийн зарчмаар хуваарилахдаа дараахь журмыг баримтална:

53.2.1.сонгуулийн босгод хүрээгүй нам, эвсэл, бие даан нэр дэвшигч үлдэгдэл хуваарилахад оролцох эрхгүй бөгөөд үлдсэн мандатыг зөвхөн сонгуулийн босгод хүрсэн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн хооронд хуваарилах;

53.2.2.нам, эвсэл, бие даан нэр дэвшигч тус бүрийн авсан бөгөөд энэ хуулийн 53.1.2-т зааснаар жагсаасан саналыг санал хуваагч буюу 1 ба түүнээс дээш дараалсан бодит тоонд хуваах;

53.2.3.энэ хуулийн 53.2.2-т зааснаар хуваахад гарсан үлдсэн суудалд ногдох хамгийн их тоог үлдэгдэлд тооцож түүнийг баримтлан мандатыг хуваарилах;

53.2.4.энэ хуулийн дагуу үлдсэн мандатыг хуваарилахад нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн авсан хүчинтэй саналын тоо тэнцвэл Сонгуулийн ерөнхий хороо шодох аргыг хэрэглэх.

53.3.Нам, эвсэлд мандат хуваарилж гүйцсэний дараа мандат хуваарилагдсан нам, эвсэл тус бүрийн нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналыг олноос цөөн рүү нь дараалуулан жагсааж гаргана.

53.4.Мандат хуваарилагдсан бие даан нэр дэвшигчийг болон энэ хуулийн 53.3-т заасан жагсаалтаар хамгийн олон санал авснаас нь дараалуулан тухайн нам, эвслийн авсан мандатын тоогоор түүний нэр дэвшигчдийг Улсын Их Хурлын гишүүнээр бүртгэж түр үнэмлэх олгоно.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**  
**САНАЛ ХУРААЛТ БОЛОН СОНГУУЛИЙГ ХҮЧИНГҮЙД ТООЦОХ,**  
**ДАХИН САНАЛ ХУРААХ, ДАХИН СОНГУУЛЬ ЯВУУЛАХ**

**54 дүгээр зүйл.Хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд**  
**тооцох, дахин санал хураах**

54.1.Тойргийн хороо дор дурдсан тохиолдолд хэсэгт явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцно:

54.1.1.байгалийн гамшиг тохиолдсон, гоц халдварт өвчин гарсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад урьд нь зарласнаас өөр байранд, түүнчлэн шилжсэн сонгогчдын саналыг битүүмжилж авснаас бусад тохиолдолд санал хураахаар зарласнаас өөр өдөр санал авсан;

54.1.2.санал хурааж эхэлснээс хойш саналын хайрцгийг алдсан, үрэгдүүлсэн, эсхүл хуульд заасан цагаас өмнө түүнийг нээсэн;

54.1.3.сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн буюу сонгогчид хүч хэрэглэн дарамт үзүүлсэн аливаа үйлдэл нь сонгогчийн санал, санал хураалтын дүнг гажуудуулахад хүргэсэн;

54.1.4.сонгуулийн хороодын дарга, нарийн бичгийн дарга, гишүүн, бусад байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 21-24, 47, 48, 53 дугаар зүйлд заасан сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, сонгогч шилжих, сонгогчийн үнэмлэх олгох, санал авах ажиллагааг зохион байгуулах, сонгогч санал өгөх, санал тоолох журмыг зөрчсөн нь тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал.

54.2.Санал хураалтыг хүчингүйд тооцвол энэ тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор дахин санал хураалт явуулна.

54.3.Дахин санал хураах шийдвэрийг тойргийн хороо гаргах бөгөөд уг шийдвэрт санал авах байр, өдрийг заах ба түүнийг ажлын өдөр явуулж болно.

54.4.Санал хураалтыг хэсгийн хэмжээгээр хүчингүйд тооцсон бол тухайн хэсгийн нийт сонгогч, зөөврийн битүүмжилсэн хайрцгаар хураасан саналыг хүчингүйд тооцсон бол уг хайрцагт саналаа өгсөн сонгогчдыг дахин санал хураалтад оролцуулна.

54.5.Дахин санал хураах ажиллагааг дуустал сонгуулийн өмнөх ухуулга хийхийг хориглоно.

## **55 дугаар зүйл.Тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох, дахин сонгууль явуулах**

55.1.Сонгуулийн ерөнхий хороо дор дурдсан тохиолдолд тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцно:

55.1.1.тухайн тойрогт аль ч нам, эвсэл энэ хуулийн 53.2.1-т заасан санал аваагүй;

55.1.2.тойргийн нийт сонгогчийн 50 хувь нь санал хураалтад оролцоогүй;

55.1.3.энэ хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хэсэгт явуулсан дахин санал хураалт хүчингүй болсон бөгөөд тэр нь тойргийн сонгуулийн дүнд ноцтой нөлөөлөхөөр байвал.

55.2.Тойрогт дахин сонгууль явуулах тухай шийдвэрийг Сонгуулийн ерөнхий хороо гаргана.

55.3.Дахин сонгуулийг тухайн тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцсон шийдвэр гарснаас хойш 25 хоногийн дотор явуулна.

55.4.Шаардлагатай бол сонгуулийн хороодыг шинэчлэн байгуулах, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх зэрэг уг сонгуулийг бэлтгэн явуулах ажилд энэ хуулийн 56 дугаар зүйлийн холбогдох заалтыг баримтална.

## **56 дугаар зүйл.Нөхөн сонгууль явуулах**

56.1.Улсын Их Хурлын гишүүн нас барсан, түүнчлэн өөр ажилд шилжсэн, эрүүл мэндийн байдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хүсэлтээрээ чөлөөлөгдсөн, эсхүл түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татсан бол Улсын Их Хурлын гишүүний орон гарсан суудалд нөхөн сонгууль явуулна.

56.2.Энэ хуулийн 56.1-д заасан шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн орон гарсан бол ийнхүү орон гарснаас хойш 30 хоногийн дотор Сонгуулийн ерөнхий хороо нөхөн сонгууль явуулах талаархи саналыг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурал уг саналыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор нөхөн сонгуулийг товлон зарлах асуудлыг шийдвэрлэж, ийнхүү шийдвэр гаргаснаас хойш 90 хоногийн дотор сонгууль явуулж дууссан байхаар тогтооно.

56.3.Нөхөн сонгуулийг товлон зарлах өдөр нь чуулганы чөлөө цагт тохиовол Улсын Их Хурал ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 14 хоногийн дотор уг асуудлыг шийдвэрлэнэ.

56.4.Нөхөн сонгууль явуулахад энэ хуулийн холбогдох заалтыг баримтлан дор дурдсан хугацаанд зохион байгуулна:

56.4.1.хэсгийг санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн өмнө, тойргийн хороог 20-иос доошгүй хоногийн өмнө, салбар хороо, сонгуулийн анхан

шатны хороо болон хэсгийн хороог 15-аас доошгүй хоногийн өмнө тус тус байгуулах;

56.4.2.нөхөн сонгуульд оролцох, нам, эвслийг тухайн сонгууль зарласнаас хойш 5 хоногийн дотор бүртгэх;

56.4.3.нэр дэвшүүлэх ажлыг нөхөн сонгууль зарласнаас хойш 5 хоногийн дараа эхэлж, 5 хоногийн хугацаанд дуусгах;

56.4.4.энэ хуулийн 56.4.3-т заасан хугацаанаас хойш 5 хоногийн хугацаанд нэр дэвшигчийг бүртгэх;

56.4.5.сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан журмын дагуу үйлдэж, санал авах өдрөөс 12 хоногийн өмнө хэсгийн хороонд өгөх;

56.4.6.хэсгийн хороо энэ хуулийн 21.7-д заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтыг шалган нэгтгэж, санал авах өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө сонгогчид танилцах бололцоогоор хангах.

56.4.7.нөхөн сонгууль эхлүүлэхээр товлон зарласан өдрөөс хойш 30 хоногийн дотор санал хураалт явуулна.

56.5.Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

56.6.Орон гарсан гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахад нэг жил хүрэхгүй хугацаа үлдсэн бол нөхөн сонгууль явуулахгүй.

## **АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **57 дугаар зүйл. Сонгуулийн хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

57.1.Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуульд<sup>10</sup> зааснаар дор дурдсан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ:

57.1.1.Эрүүгийн хуулийн 130.1-д зааснаар иргэний сонгох, сонгогдох, бүх нийтийн санал асуулгад оролцох эрхээ хэрэгжүүлэхэд болон сонгуулийн

---

<sup>10</sup> Эрүүгийн хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

хорооноос хуулийн дагуу явуулж байгаа аливаа ажиллагаанд санаатай саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэх;

57.1.2.Эрүүгийн хуулийн 130.2-т зааснаар энэ хэргийг хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх, хуурч мэхлэх, эд мөнгөөр татах, санал худалдаж авах зэрэг аргаар үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг далан нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэх;

57.1.3.Эрүүгийн хуулийн 131,1-д зааснаар сонгуулийн болон бүх нийтийн санал асуулгыг зохион байгуулах хорооны дарга, гишүүн, бусад албан тушаалтан сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50.3-т заасныг ноцтой зөрчиж санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан, 57.4-т заасныг ноцтой зөрчиж буруу шийдвэрлэсэн, мөн сонгогчоос санал нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн, түүнчлэн сонгуулийн дүнд хууль бусаар нөлөөлсөн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэх.

57.2.Энэ хуульд заасан зөрчил гаргаж, захиргааны хариуцлага хүлээсэн нь уг этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

57.3.Сонгуулийн хууль тогтоомжид заасан зохих журмыг зөрчсөн, хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эрх мэдлээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах замаар сонгогчдын эрхийг зөрчсөн дараахь этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

57.3.1.сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг 100000-250000 төгрөгөөр торгох;

57.3.2.Засаг даргыг 150000-250000 төгрөгөөр торгох;

57.3.3.нам, эвслийг 700000-1000000 төгрөгөөр, нэр дэвшигчийг 100000-250000 төгрөгөөр, нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, бие даан нэр дэвшигчийн шадар туслагчийг 100000-200000 төгрөгөөр тус тус торгох;

57.3.4.сонгуулийн ажиглагчийг 100000-150000 төгрөгөөр торгох;

57.3.5.хэвлэл, мэдээллийн байгууллагыг 600000-800000 төгрөгөөр, ажилтныг 100000-200000 төгрөгөөр тус тус торгох;

57.3.6.банкийг 800000-1000000 төгрөгөөр, банкны захирлыг 200000-250000 төгрөгөөр тус тус торгох;

57.3.7.энэ хуулийн 57.3.1-57.3.6-д зааснаас бусад хуулийн этгээдийг 500000-700000 төгрөгөөр, албан тушаалтныг 150000-250000 төгрөгөөр, иргэнийг 100000-150000 төгрөгөөр тус тус торгох.

57.4.Улс төрийн нам, эвсэл, тэдгээрийн нэр дэвшигч түүнчлэн бие даан нэр дэвшигч сонгогчдыг эд мөнгөөр татах, хууль бус амлалт хийх, төөрөгдүүлэх оролдлого хийсэн нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бол нам, эвслийн сонгуульд оролцох батламжийг Сонгуулийн ерөнхий хороо хүчингүй болгох, нэр дэвшигчийг нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасах арга хэмжээг тойргийн хороо авна.

57.5.Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд Иргэний хууль болон холбогдох бусад хуульд заасан эд материалын хариуцлага хүлээлгэнэ.

## **58 дугаар зүйл.Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн маргааныг шийдвэрлэх харьяалал**

58.1.Энэ хуульд сонгуулийн хороод харьяалан шийдвэрлэхээр заасан зөрчил гарсан бол гомдлыг холбогдох сонгуулийн хороонд гаргана.

58.2. Энэ хуульд заасан захиргааны шийтгэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч ногдуулах ба түүнд давж заалдсан гомдлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу сум буюу сум дундын, дүүргийн шүүх хянан шийдвэрлэнэ.

58.3.Энэ хуулийн холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Эрүүгийн болон Иргэний хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байвал асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль<sup>11</sup> болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журам, харьяаллын дагуу шийдвэрлэнэ.

58.4.Энэ хуульд заасан зөрчил гаргасан сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүнийг түүний бүрэлдэхүүнээс гаргах асуудлыг тухайн шатны сонгуулийн хороо бүрэлдэхүүнээрээ хэлэлцэж шийдвэрлэнэ.

---

<sup>11</sup> Эрүүгийн байцаан шийтгэх хууль-“Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

58.5.Сонгуулийн ерөнхий хороо энэ хуулийн 27.3-т заасны дагуу нам, эвслийг бүртгэхээс татгалзсан асуудлаар гарсан маргааныг 14 хоногийн дотор, тойрогт явуулсан сонгуулийг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, 32.10-т заасны дагуу нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан, тойргийн хороо 32.16, 40.9, 42.5, 43.7-д заасны дагуу нэр дэвшигчийг нэрийн жагсаалтаас хасах, түүнчлэн санал хураалтыг хүчингүйд тооцох асуудлаар гарсан маргааныг санал хураалт явуулсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тус тус эцэслэн шийдвэрлэнэ.

58.6.Сонгуулийн ерөнхий хороо нь холбогдох хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтийг үндэслэн энэ хуулийн 42.5, 43.7, 44.10-т заасан хөрөнгийг улсын орлого болгох тухай болон энэ хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах тухай нэхэмжлэлийг сум буюу сум дундын, дүүргийн шүүхэд гаргах бөгөөд шүүх уг асуудлыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

58.7.Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийн талаар Сонгуулийн ерөнхий хорооны гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар гарсан маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ.

### **59 дүгээр зүйл.Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах**

59.1.Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх зургаан сарын дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах буюу түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.

Гарын үсэг